



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХАРИУЦЛАГЫН БОЛОН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО СУЛ БАЙГААГААС
УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТЭД
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ЗӨРЧИГДСӨӨР БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

АУДИТЫН КОД: АГГ-2021/06-ШТА-ГА



Улаанбаатар хот
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Д.Энхболд

Утас: 263755 Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Б.Саруул

Утас: 261805 Цахим хаяг: saruulb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Батдэлгэр

Аудитор Б.Хаш-Эрдэнэ

Ч.Баярмаа

Б.Мөнхтуяа

М.Доржмаа

Ж.Оюунтуяа

Г.Оргилмаа

С.Одонцэцэг

Ш.Наранбаатар

Ж.Мөнхбилгүүн

Э.Уужимсан

М.Сангижанцан



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.3, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар /Б.Бундхорол/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд хүргүүлэхийг Аудитын гуравдугаар газар /Д.Энхболд/-т тус тус даалгасугай.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /Л.Оюун-Эрдэнэ/, Сангийн сайд /Б.Жавхлан/, холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор /Ц.Наранчимэг/-т даалгасугай.

5. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Аудитын гуравдугаар газар /Д.Энхболд/-т даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Батдэлгэр/-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

Z:\Tushaal\2021\EA-In A Tushaal\0610auditin 3-R Gazar1.Docx

001010803

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хавсралтууд	4
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	4
Графикийн жагсаалт	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	6
<i>Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:</i>	6
<i>Аудитын зорилт:</i>	6
<i>Аудитын хамарсан хүрээ:</i>	6
<i>Аудитын арга зүй:</i>	6
<i>Аудитын шалгуур үзүүлэлт:</i>	7
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	8
БҮЛЭГ 1. ХАРИУЦЛАГЫН БОЛОН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО СУЛ БАЙГААГААС УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТӨД ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧМЫГ БҮРЭН БАРИМТЛААГҮЙ БАЙНА	12
<i>Монгол Улсын хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг хоорондын уялдаа бүрэн хангагдахгүй байгаа нь зарим салбарын бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна</i>	12
<i>Төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн саналаа боловсруулахад болон улсын төсвийн хөрөнгийн зардлыг хуульд батлахад төсвийн хязгаарыг баримтлаагүй байна</i>	14
<i>Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн саналд тусаагүй 185 барилга, байгууламжийг Засгийн газар, УИХ-ын хэлэлцүүлгийн үе шатанд нэмж хэрэгжүүлэхээр баталсан байна</i>	15
<i>Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 334 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ</i>	16
<i>Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн нормативт суурилсан төсөвлөлтийг хийгээгүйгээс төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан тохиолдол гарсан байна</i>	17
<i>Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хүн амын тоотой бүрэн уялдуулж төлөвлөх шаардлагатай байна</i>	18
<i>Хариуцлагын болон хяналтын тогтолцоо сул байгаагаас төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол буурч байна</i>	19
<i>Төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаатай уялдуулж санхүүжилтийг төлөвлөөгүй, мөн төрийн өмчид бүртгэгдэхгүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг зөрчил хэвээр байна</i>	19
<i>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд өмнөх оноос үргэлжлэх төсөл, арга хэмжээнд хангалттай хөрөнгө төсөвлөөгүйгээс дуусаагүй, орхигдсон барилга нэмэгдэх эрсдэл байна</i>	21
<i>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системийг 2020 оны төсвийн төлөвлөлтөд хэрэгжүүлсэн ч төслүүдийг батлах үе шатанд системээр төлөвлөөгүй төслүүдийг тусгасан нь үр ашиггүй төсөл, арга хэмжээ хэрэгжих үр дагавартай байна</i>	21
БҮЛЭГ 2. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ БҮРЭН ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСНААС ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭХ, ХЭРЭГЖИЛТ УДААШРАХ, ҮР АШИГГҮЙ ЗАРДАЛ ГАРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА	24
<i>Худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулаагүйгээс төсөл, арга хэмжээний гүйцэтгэл тайлант онд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүсжээ</i>	24

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагчдад Сангийн яамнаас өгсөн дундаж үнэлгээ 74.7 хувьтай байна.....	25
Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад ТБОНӨХБАҮХАТХ болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийн зохицуулалт зөрчигдсөөр байна	26
Магадлалаар баталгаажаагүй төсөвт өртгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас үр ашиггүй зардал гарах эрсдэлийг үүсгэсэн байна.....	30
Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт бодит гүйцэтгэлээр 78.4 хувьтай байна	30
Төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээг баталснаас санхүүжилтийг он дамжуулан хэрэгжүүлэх шаардлага үүссэн байна	31
Төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд батлуулснаас хөрөнгийн зохицуулалт хийх шаардлага үүссэн байна.....	31
Барилга угсралтын үе шатны ажилд зохиогчийн техникийн хяналт хийх гэрээг ТЭЗ байгуулаагүйгээс эрх зүйн зохицуулалт зөрчигдөж байна.....	32
Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 11.2 хувь буюу 151 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 15.2 хувь буюу 205 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дутуу байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна	32
Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээр 353.7 тэрбум төгрөгийн 385 зөрчил илэрсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.....	33
Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хууль, эрх зүйн зохицуулалт зөрчигдсөөр байна.....	34
ДҮГНЭЛТ:	47
ЗӨВЛӨМЖ:	49
Холбогдох байгууллагын санал	51
Саналд өгөх тайлбар	53
Хавсралт 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн дуусаагүй орхигдсон барилгуудын судалгаа.....	54
Хавсралт 2. Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд хэрэгжилт нь батлагдсан төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт	56
Хавсралт 3. Магадлалаар баталгаажсан төсөвт өртгөөс гэрээний дүн давсан төсөл, арга хэмжээний жагсаалт	57
Хавсралт 4. Монгол Улсын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	58
Хавсралт 5. Монгол Улсын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжилт дутуу төсөл, арга хэмжээний жагсаалт	63

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын Олон Улсын байгууллага
АТГД	Авлигатай тэмцэх газрын дарга
БД	Барилгын дүрэм
БГД	Баянгол дүүрэг
БНБД	Барилгын норм ба дүрэм
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХС	Зам, тээврийн хөгжийн сайд
ЗГХЭГД	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУИХД	Монгол Улсын Их Хурлын дарга
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУШС	Монгол Улсын Шадар сайд
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
СБД	Сүхбаатар дүүрэг
СаС	Сангийн сайд
СоС	Соёлын сайд
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТОӨЗ	Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБ	Улаанбаатар
УДШЕШ	Улсын Дээд Шүүхийн ерөнхий шүүгч
УЕП	Улсын ерөнхий прокурор
УИХ	Улсын Их Хурал
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮСХД	Үндэсний статистикийн хорооны дарга
ҮХЦД	Үндсэн хуулийн цэцийн дарга
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ШЕЗД	Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга
ЭМС	Эрүүл мэндийн сайд

ЭХС	Эрчим хүчний сайд
-----	-------------------

Хавсралтууд

Дугаар	Хавсралтын нэр	Хуудасны дугаар
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн дуусаагүй орхигдсон барилгуудын жагсаалт	53
2	Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд хэрэгжилт нь батлагдсан төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт	55
3	Магадлалаар баталгаажсан төсвөөс гэрээний дүн давсан төсөл, арга хэмжээний жагсаалт	56
4	Монгол Улсын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	57
5	Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын тусгагдсан хэрэгжилт дутуу төсөл, арга хэмжээний жагсаалт	62

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Дугаар	Нэр	Хуудасны дугаар
1	Улсын төсвийн 2019, 2020 оны хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/	9
2	Төсөл, арга хэмжээний санхүүжилт, ажлын гүйцэтгэл /тэрбум төгрөг/	10
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж ашиглалтад орсон барилга, байгууламжийн судалгаа /хүчин чадал/	10
4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын салбараар ангилсан судалгаа /тэрбум төгрөг/	11
5	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөс Монгол Улсын 2020 төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд батлагдаагүй төсөл, хөтөлбөрийн жагсаалт /сая төгрөг/	12
6	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй Төсвийн тухай хуулиар батлагдсан 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй ТАХ-ний жагсаалт /сая төгрөг/	13
7	Төсвийн хязгаарыг ТЕЗ-дын төсвийн санал болон батлагдсан төсөвтэй харьцуулсан байдал /тэрбум төгрөг/	14
8	Улсын төсвийн 2019, 2020 оны хөрөнгө оруулалтын харьцуулалт, төсөвт өртөг, санхүүжих дүн, төсөл, арга хэмжээний тоо /тэрбум төгрөг/	15
9	ТЕЗ-дын төсвийн саналд үндэслэж төсвийг баталсан байдал /тоо, сая төгрөг/	15
10	Шинээр эхлүүлэх ТАХ-ний зураг төсөв баталгаажсан байдал /тоо, эзлэх хувь/	16
11	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд батлагдсан хэрэгцээ, шаардлагагүй ерөнхий боловсролын сургуулийн барилга	18
12	Улсын төсвийн хөрөнгөөр 6 буюу түүнээс дээш жил санхүүжиж байгаа төсөл, арга хэмжээний дүн	19
13	Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан зарим төсөл, арга хэмжээний жишээ /сая төгрөг/	20
14	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бус шинжтэй зарим төсөл, арга хэмжээний жагсаалт /сая төгрөг/	20
15	ТЕЗ нарын худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээ /хувиар/	25
16	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилтийн дүн /сая төгрөг/	30
17	ТЕЗ-дын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зохицуулалт хийсэн хөрөнгийн зардлын дүн /сая төгрөг/	31
18	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын илрүүлсэн зөрчил /сая төгрөг/	33

19	ТЕЗ-даас орон нутагт эрх шилжүүлээгүй ТАХ-ний хэрэгжилтэд илрүүлсэн зөрчил /сая төгрөг/	34
----	---	----

Графикийн жагсаалт

Дугаар	Графикийн нэр	Хуудасны дугаар
1	Нэгдсэн төсөв болон улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн, нэгдсэн төсвийн хөрөнгийн зарлагад улсын төсвийн хөрөнгийн зарлагын эзлэх хэмжээ /хувь, тэрбум төгрөг/	9
2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн судалгаа /тэрбум төгрөг/	11
3	Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний санхүүжилтийг байршлаар харуулбал /ТАХ-ний тоо, тэрбум төгрөг/	18
4	ТЕЗ-дын худалдан авах ажиллагаа зохион байгуулсан хугацаа /хувь, сараар/	24

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/28 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд санхүүжүүлэхээр баталсан 1347 төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний харьяа байгууллага болон төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журамд заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавихтай холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Мөн аудитад барилгын салбарт мөрдөгдөж буй норм, норматив, стандартын өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох зорилгоор хөндлөнгийн мэргэжлийн шинжээчийг татан оролцуулсан.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Дараах хууль, эрх зүйн актыг аудитын гол шалгуур үзүүлэлтээр эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль /хуучин нэрээр/;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл;
- Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”;
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт;
- Төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнгийн үзүүлэлт;
- Төсөл, арга хэмжээний зардал, үр ашгийн тооцоолол;
- Төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байсан эсэх;
- Барилгын норм ба дүрэм, бусад эрх зүйн актууд.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УИХ-аас 2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг баталснаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэн, нэгдсэн оновчтой тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгосон байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д *“Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна”* гэж заасан байна.

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн салбар болон салбар хоорондын уялдааг хангасан байхаас гадна улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хавсралтаар батлахаар зохицуулж, улсын төсвийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүжилтийн нэг эх үүсвэр байхаар хуульчилсан байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 23 ТЕЗ-ийн төсвийн багцад 5,307.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1439 төсөл, арга хэмжээнд 2,152.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан боловч Дэлхий даяар эрчимтэй тархаад байгаа шинэ төрлийн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахал нь Монгол Улсын нийгэм, эдийн засагт урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал үүсгэсний улмаас УИХ-аас 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр уг хуульд өөрчлөлт оруулж 5,175.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1356 төсөл, арга хэмжээнд 1,654.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.


Хуулийн өөрчлөлтөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 498.2 тэрбум төгрөгөөр бууруулсныг ангилж үзвэл, шинээр 35.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээнд 18.4 тэрбум төгрөгийг баталж, 117.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 44.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 98 төсөл, арга хэмжээг хасаж, 2,433.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 576 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 474.2 тэрбум төгрөгөөр бууруулж, 3.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэлд хөрөнгийн зардлын хэмжээг 3,408.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 8.8 хувьтай тэнцэхээр баталснаас гүйцэтгэлээр 3,034.2 тэрбум төгрөг буюу ДНБ-д эзлэх хэмжээ 8.2 хувь байгаа нь төсвийн хүрээний мэдэгдлээс 0.6 нэгж хувиар бага байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны гүйцэтгэлээр нийт хөрөнгийн зардлын 1,093.6 тэрбум төгрөг буюу 36.0 хувийг улсын төсөв, 321.0 тэрбум төгрөг буюу 10.6 хувийг концессын эргэн төлөлт, 396.5 тэрбум төгрөг буюу 13.1 хувийг стратегийн болон бусад хөрөнгийн санхүүжилт, 957.4 тэрбум төгрөг буюу 31.5 хувийг гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, 265.7 тэрбум төгрөг буюу 8.8 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 10.2 хувь, улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 13.2 хувь, нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын 46.6 хувийг эзэлж байгаа нь сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

График 1. Нэгдсэн төсөв болон улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн, нэгдсэн төсвийн хөрөнгийн зарлагад улсын төсвийн хөрөнгийн зарлагын эзлэх хэмжээ



Эх сурвалж: УАГ, УСХ, Сангийн яам

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтыг “Соёл, урлагийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ач холбогдол бүхий төслүүдийг хэрэгжүүлэх”, “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх”, “Гаалийн шинэчлэл төслийг хэрэгжүүлэх”, “Сумын төвийн шинэчлэл төсөл”, “Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх”, “Эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд ойр байлгах, эмнэлгийн орчин нөхцөлийг сайжруулах” бодлогын зорилтуудыг хангахад голлон чиглүүлжээ.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар баталсан 1347 төсөл, арга хэмжээнээс 2,308.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 778.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 503 төсөл, арга хэмжээ буюу 37.3 хувь нь өмнөх оноос үргэлжилсэн, 1,809.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 552.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 844 төсөл, арга хэмжээ буюу 62.7 хувийг тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг өмнөх онтой харьцуулахад төсөл, арга хэмжээний тоо 66 буюу 5.2 хувиар нэмэгдэж, санхүүжих дүн 222.5 тэрбум төгрөг буюу 16.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Улсын төсвийн 2019, 2020 оны хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/

Санхүүжилтийн эх үүсвэр	2019 он				2020 он				Өмнөх жилээс өссөн, буурсан	
	ТАХ-ний тоо	Санхүү-жих дүн	Санхүүжилт Дүн	Хувь	ТАХ-ний тоо	Санхүү-жих дүн	Санхүүжилт Дүн	Хувь		
Улсын төсөв	1281	1,553.4	1,422.6	91.6	1347	1,330.9	1,093.6	82.2	(222.5)	(329)
Концессын эргэн төлөлт	12	144.7	137.4	95.0	9	323.5	321.0	99.2	178.8	183.6
Нийт дүн	1293	1,698.1	1,560.0	91.9	1356	1,654.4	1,414.6	85.5	(43.7)	(145.4)

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 1,330.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоос 1,093.6 тэрбум төгрөг буюу 82.2 хувь, концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 9 төслийн эргэн төлөлтөд 323.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоос 321.0 тэрбум төгрөг буюу 99.2 хувийг тус тус олгож, нийт төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийг Сангийн яамнаас 1,414.6 тэрбум төгрөг буюу 85.5 хувь гэж тайлагнажээ.

Хүснэгт 2. Төсөл, арга хэмжээний санхүүжилт, ажлын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Д/д	ТЕЗ	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүү-жих дүн	Санхүүжилтийн гүйцэтгэл		Үүнээс:				Зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ	
							Ажлын бодит гүйцэтгэлээр		ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан			
					Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	МУИХД	1	2.4	2.4	2.0	83.3	2.0	83.3	-	-	0.4	16.7
2	МУЕС	40	192.5	30.9	24.0	77.7	24.0	77.7	-	-	6.9	22.3
3	МУШС	12	40.6	10.3	10.1	98.1	10.1	98.1	-	-	0.2	1.9
4	ЗГХЭГД	80	96.6	47.3	43.0	90.9	42.5	89.9	0.5	1.0	4.3	9.1
5	БОАЖС	29	41.9	17.6	14.6	83.0	14.4	81.8	0.2	1.2	3.0	17.0
6	БХС	5	23.0	9.0	9.0	100.0	9.0	100.0	-	-	0.0	0.0
7	ГХС	2	2.6	2.6	2.6	100.0	2.6	100.0	-	-	0.0	0.0
8	СаС	11	266.0	102.6	80.1	78.1	69.0	67.3	11.1	10.8	22.5	21.9
9	ХЗДХС	25	71.7	50.6	50.1	99.0	50.01	98.8	0.09	0.2	0.5	1.0
10	ХНХС	36	46.9	12.7	9.7	76.4	8.6	67.7	1.1	8.7	3.0	23.6
11	БХБС	213	489.9	179.1	141.8	79.2	139.5	77.9	2.3	1.3	37.3	20.8
12	БШУС	437	949.5	323.4	261.4	80.8	256.9	79.4	4.5	1.4	62.0	19.2
13	СоС	115	671.1	144.3	105.4	73.0	83.3	57.7	22.1	15.3	38.9	27.0
14	ЗТХС	127	656.6	209.4	190.9	91.2	190.9	91.2	-	-	18.5	8.8
15	УУХҮС	4	5.8	4.1	3.8	92.7	3.8	92.7	-	-	0.3	7.3
16	ХХААХҮС	34	35.3	21.4	8.2	38.3	8.2	38.3	-	-	13.2	61.7
17	ЭХС	30	194.9	32.3	18.4	57.0	18.4	57.0	-	-	13.9	43.0
18	ЭМС	133	295.7	120.0	108.2	90.2	100.5	83.8	7.7	6.4	11.8	9.8
19	АТГД	2	1.1	1.1	1.1	100.0	1.1	100.0	-	-	0.0	0.0
20	УЕП	7	31.9	7.6	7.0	92.1	6.1	80.3	0.9	11.8	0.6	7.9
21	МУЕА	2	1.0	1.0	1.0	100.0	1.0	100.0	-	-	0.0	0.0
22	ҮСХД	1	0.6	0.6	0.6	100.0	0.6	100.0	-	-	0.0	0.0
23	ҮХЦД	1	0.6	0.6	0.6	100.0	0.6	100.0	-	-	0.0	0.0
Улсын төсвийн дүн		1347	4,118.2	1,330.9	1,093.6	82.2	1,043.2	78.4	50.4	3.8	237.3	17.8
Концессын дүн		9	1,057.1	323.5	321.0	99.2	321.0	99.2	-	-	2.5	0.8
Нийт		1356	5,175.3	1,654.4	1,414.6	85.5	1,364.2	82.5	50.4	3.0	239.8	14.5

Эх сурвалж: УАГ, Сангийн яам

Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийг авч үзвэл, төлөвлөсөн санхүүжилтийн 78.4 хувь буюу 1,043.2 тэрбум төгрөгийг ажлын бодит гүйцэтгэлээр олгож, Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолын хүрээнд 3.8 хувь буюу 50.4 тэрбум төгрөгийг ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Харин ТЕЗ-дын тайлант онд зарцуулагдаагүй үлдэгдэл 17.8 хувь буюу 237.3 тэрбум төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн бөгөөд үүний 13.1 хувь буюу 31.1 тэрбум төгрөг нь худалдан авах ажиллагааны хэмнэлт, 71.9 хувь буюу 170.5 тэрбум төгрөг нь ажлын гүйцэтгэл гараагүй, 15.0 хувь буюу 35.7 тэрбум төгрөг нь гэрээ байгуулаагүйгээс тус тус шалтгаалжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 10800 суудалтай 30 сургууль, 8515 ортой 64 цэцэрлэг, 2145 ортой 22 дотуур байр, 645 ортой 22 эмнэлэг, 155.9 км автозам, 659.6 у/м гүүрийн байгууламж, 326.1 км ЦДАШ, 4240 суудалтай 17 соёлын төв тус тус ашиглалтад орсон байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэн комисс хүлээн авч, байнгын ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээний үр дүнг салбараар гаргаж өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад эрчим хүчнээс бусад салбарын барилга, байгууламжийн хүчин чадал өссөн үзүүлэлттэй байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 3-аас харна уу)

Хүснэгт 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж ашиглалтад орсон барилга, байгууламжийн судалгаа /хүчин чадал/

Барилга, байгууламжийн ангилал	Хэмжих нэгж	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	Өмнөх 5 жилийн дунджаас өссөн, буурсан
Хатуу хучилттай авто зам	км	1171.9	176.6	844.8	135.5	63.6	155.9	322.6
Төмөр бетон гүүр	у/м	586.2	289.9	509.6	202.4	341.7	659.6	273.6
ЦДАШ	км	562.4	65.3	0	150	2000	326.1	(229.4)

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (АГГ-2021/06-ШТА-ГА)

Цэцэрлэг	орны тоо	1820	2170	4295	1580	10455	8515	4451
Сургууль	суудлын тоо	7280	8008	15070	3968	17110	10800	512.8
Дотуур байр	орны тоо	1270	620	900	170	1580	2145	1237
Соёлын төв	суудлын тоо	2320	1400	0	1050	4180	4240	2450
Хүн эмнэлэг	орны тоо	460	545	110	60	348	645	340.4

Эх сурвалж: УАГ

Тайлант оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дүнг салбараар нь авч үзвэл, нийгмийн салбарт 47.5 хувь буюу 631.3 тэрбум, дэд бүтцийн салбарт 31.6 хувь буюу 420.8 тэрбум, бусад салбарт 20.9 хувь буюу 278.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр хуваарилсан байна.


Хүснэгт 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын салбараар ангилсан судалгаа /тэрбум төгрөг/

Салбарын ангилал	2019 он		2020 он		Өмнөх жилтэй харьцуулахад өссөн, буурсан дүн
	Дүн	Хувь	Дүн	Хувь	
Дэд бүтэц	480.3	30.9	420.8	31.6	(59.5)
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	616.5	39.7	498.6	37.5	(117.9)
Эрүүл мэнд	104.2	6.7	120.0	9.0	15.8
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	33.9	2.2	12.7	1.0	(21.2)
Төрийн төв байгууллагууд	214.8	13.8	176.1	13.2	(38.7)
Хууль сахиулах, батлан хамгаалах	58.4	3.8	59.6	4.5	1.2
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй	43.3	2.8	39.0	2.9	(4.3)
Хүнд үйлдвэр	2.0	0.1	4.1	0.3	2.1
Дүн	1,553.4	100.0	1,330.9	100.0	(222.5)

Эх сурвалж: УАГ, Сангийн яам

Дээрх хүснэгтээс үзэхэд, 2020 онд эрүүл мэнд, хууль сахиулах, батлан хамгаалах, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалт өмнөх оноос 1.2-15.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, бусад салбарын хөрөнгө оруулалт 4.3-117.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

График 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн судалгаа /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 85.5 хувьтай байгаа нь өмнөх таван жилийн дундажтай харьцуулахад 2.2 пунктээр доогуур байна.

БҮЛЭГ 1. ХАРИУЦЛАГЫН БОЛОН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО СУЛ БАЙГААГААС УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТӨД ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧМЫГ БҮРЭН БАРИМТЛААГҮЙ БАЙНА

Монгол Улсын хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг хоорондын уялдаа бүрэн хангагдахгүй байгаа нь зарим салбарын бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна

1.1. Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотгол”-д 2020 онд үргэлжлэн хэрэгжих 17 төсөл, хөтөлбөрт 397.7 тэрбум, шинээр хэрэгжих 9 төсөл, хөтөлбөрт 424.6 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгаснаас Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуульд 6 ТЕЗ-ийн гадаадын зээл, тусламжаар хэрэгжих 9 төсөл, хөтөлбөрийн Монголын талын хөрөнгө оруулалт 70.0 тэрбум, улсын төсвөөс шууд санхүүжих БХС-ын багцын 20.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, хөтөлбөрийг орхигдуулж баталсан байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 5-аас харна уу)

Хүснэгт 5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөс Монгол Улсын 2020 төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд батлагдаагүй төсөл, хөтөлбөрийн жагсаалт /сая төгрөг/

Д/д	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Санхүүжих дүн
1	МУЕС	Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл	1,537.8
2	БШУС	Дээд боловсролын шинэчлэл төсөл	2,461.8
3	БШУС	Өрсөлдөх чадвартай дээд боловсрол төсөл	1,579.2
4	ЗТХС	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал төслийн нэмэлт санхүүжилт	57,445.9
5	ЗТХС	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 2 дахь шатны төсөл	3,000.0
6	Сангийн сайд	Нүхэн гарц төсөл	1,000.0
7	Сангийн сайд	Туул, Сэлбэ голын урсцыг нэмэгдүүлж, орчмыг сайжруулах төсөл	1,000.0
8	ХХААХҮС	Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих техникийн шинэчлэл хийх төсөл	1,000.0
9	ЭХС	Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд усан цахилгаан станц барих төсөл, 64 МВт	1,000.0
10	БХС	Инженерийн рот	20,000.0
Нийт			90,024.7

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоол

1.2. Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-т заасны дагуу “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хавсралтаар Улсын Их Хурал батлах, мөн Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 28 дугаар зүйлийн 28.8-д зааснаар Засгийн газар батлах зохицуулалттай байгаа нь хууль хоорондын зөрчлийг үүсгэж, улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тодорхойгүй байдлыг үүсгэхээр байна.

1.3. Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна” гэж заасан байна.

1.4. Мөн хуульд Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ТЕЗ-даас ирүүлсэн 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй төсөл, арга хэмжээний саналд эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын судалгаа хийж үр дүнтэй болох нь тогтоогдсон тохиолдолд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаж, Засгийн газраар батлуулахаар байна.

1.5. Гэвч Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт батлагдаагүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээг баталсан байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоог гажуудуулсан байна. Үүнд:

Хүснэгт 6. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаадаагүй Төсвийн тухай хуулиар батлагдсан 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй ТАХ-ний жагсаалт /сая төгрөг/

Д/д	ТАХ-ний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Санхүүжсэн дүн
		Эхлэх	Дуусах			
1	Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн /Улаанбаатар/	2020	2021	80,000.0	500.0	-
2	Шинжлэх ухаан, инновацийн төвийн класстер /Улаанбаатар/ Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгын зураг төсөв	2020	2022	94,000.0	3,000.0	-
3	боловсруулах, барилгыг шинэчлэх ажлыг эхлүүлэх /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2020	2022	54,607.5	500.0	-
4	Төв номын сангийн барилгын зураг төсөв боловсруулах, барилгыг шинэчлэх ажлыг эхлүүлэх /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2020	2021	52,409.4	500.0	-
5	Улсын драмын эрдмийн театрын барилгын зураг төсөв боловсруулах, барилгыг шинэчлэх ажлыг эхлүүлэх /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2020	2022	52,025.0	500.0	-
6	Чингис хаан музейн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2020	2021	50,066.5	48,779.7	47,998.2
7	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/	2019	2021	41,600.0	5,487.1	5,282.3
8	Чингис хот - Дадал сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 50 км /Хэнтий/	2020	2022	45,000.0	2,500.0	2,500.0
9	Дулааны цахилгаан станцын өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/	2020	2022	52,000.0	7,000.0	-
Нийт				521,708.4	68,766.8	55,780.5

Эх сурвалж: Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоол

1.6. УИХ-ын 2019 оны 54 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д улсын төсвийн хөрөнгө оруулалт болон холимог эх үүсвэр (гадаад эх үүсвэр, улсын төсөв)-ээс эдийн засгийн ангиллаар 29 зорилт, арга хэмжээг 1,313.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгаснаас Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд 433.6 тэрбум төгрөгөөр санхүүжих дүнтэй 8 зорилт, арга хэмжээ батлагдаагүй байна.

1.7. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль /хуучин нэрээр/-ийн 12 дугаар зүйлийн 12.9-д “Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна” гэж заасантай нийцэхгүй байна.

1.8. Монгол Улсын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого хоорондын уялдаа бүрэн хангагдахгүй байгаа нь улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт хэрэгжихгүй байх эрсдэлийг дагуулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид төсвийн саналаа боловсруулахад болон улсын төсвийн хөрөнгийн зардлыг хуульд батлахад төсвийн хязгаарыг баримтлаагүй байна

1.9. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1¹-д заасан хугацаанд ирүүлсэн ТЕЗ-дын саналд үндэслэн 2020 оны төсвийн хязгаарыг боловсруулж, мөн хуулийн 8.3.3²-т заасны дагуу Засгийн газрын 2019 оны 254 дүгээр тогтоолоор нийт 31 ТЕЗ-ийн 2020 оны төсвийн зарлагын дээд хязгаарыг баталснаас 15 ТЕЗ-д хөрөнгийн зардлын хязгаарыг 1,717.0 тэрбум төгрөгөөр баталжээ.

1.10. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд дээрх төсвийн хязгаарт тусгагдаагүй 7 ТЕЗ-ийн 22.1 тэрбум, төсвийн хязгаараас давуулж 12 ТЕЗ-ийн 689.1 тэрбум төгрөгийн хөрөнгийн зардлыг баталсан байна.

Хүснэгт 7. Төсвийн хязгаарыг ТЕЗ-дын төсвийн санал болон батлагдсан төсөвтэй харьцуулсан байдал /тэрбум төгрөг/

Д/д	ТЕЗ	ТЕЗ-дын төсвийн батлагдсан хөрөнгийн зардлын хязгаар	ТЕЗ-даас Сангийн яаманд хүргүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний төсвийн санал		Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль				Төсвийн хязгаар болон төсвийн саналын зөрүү	Төсвийн хязгаар болон батлагдсан төсвийн зөрүү
			ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн баталсан	2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн баталсан	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн		
	1	2	3	4	5	6	7	8	9=4-2	10=6-2
1	МУИХД	-	-	-	2	2.6	1	2.4	-	2.6
2	МУЕС	330.4	54	180.2	19	347.1	40	30.9	(150.2)	16.7
3	МУШС	15.8	139	87.8	11	9.9	12	10.3	72.0	(5.9)
4	ЗГХЭГД	18.0	162	155.9	76	32.5	89	370.8	137.9	14.5
5	CaC	416.1	-	-	11	175.1	11	102.6	(416.1)	(241.0)
6	ХЗДХС	12.6	145	239.4	25	51.0	25	50.6	226.8	38.5
7	БОАЖС	21.1	180	189.0	30	25.4	29	17.6	167.9	4.3
8	БХС	5.2	20	71.0	6	11.1	5	9.0	65.8	5.9
9	ГХС	-	55	101.4	2	2.6	2	2.6	101.4	2.6
10	БСШУСС	289.8	1348	2,609.7	614	662.4	437	323.4	2,319.9	372.6
11	СоС	-	-	-	-	-	115	144.3	-	-
12	ЗТХС	319.4	348	1,942.9	140	311.0	127	209.4	1,623.5	(8.4)
13	УУХҮС	24.6	11	30.1	3	4.2	4	4.1	5.5	(20.4)
14	ХНХС	11.4	83	165.2	42	25.5	36	12.7	153.8	14.1
15	ХХААХҮС	13.9	45	81.4	37	15.2	34	21.4	67.5	1.3
16	ЭМС	79.3	595	508.8	131	133.8	133	120.0	429.5	54.5
17	ЭХС	46.5	82	230.1	34	72.6	30	32.3	183.6	26.2
18	БХБС	113.0	124	866.9	241	251.0	213	179.1	753.9	138.0
19	АТГД	-	7	1.7	2	1.1	2	1.1	1.7	1.1
20	УЕП	-	72	35.3	7	11.7	7	7.6	35.3	11.7
21	УДШЕШ	-	3	5.9	1	4.5	-	-	5.9	4.5
22	МУЕА	-	2	2.2	2	1.0	2	1.0	2.2	1.0
23	ҮСХД	-	1	0.6	1	0.7	1	0.6	0.6	0.7
24	ҮХЦД	-	1	0.6	1	0.6	1	0.6	0.6	0.6
	Нийт	1,717.0	3477	7,506.1	1438	2,152.6	1356	1,654.4	5,789.1	435.5

Эх сурвалж: Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 254 дүгээр тогтоол

1.11. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3³-т заасны дагуу ТЕЗ-д 2020 оны төсвийн саналаа 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснийг мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4⁴, 8.4.5⁵-д заасны дагуу Сангийн яам нэгтгэн боловсруулж, Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх.

² Засгийн газар төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн жил бүрийн 7 дугаар сарын 01-ний дотор батлах.

³ Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

⁴ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт өргөн мэдүүлэх.

⁵ Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор УИХ-д өргөн мэдүүлэх.

1.12. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн төсөлд 21 ТЕЗ-аас нийт 3477 төсөл, арга хэмжээг 7,506.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх саналыг Сангийн яаманд хүргүүлснийг Засгийн газрын 2019 оны 254 дүгээр тогтоолоор баталсан ТЕЗ-дын 2020 оны хөрөнгийн зардлын төсвийн хязгаартай харьцуулахад 4.4 дахин их байна.

1.13. Энэ нь салбарын хэмжээнд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгцээ, шаардлага, үр ашгаар нь эрэмбэлдэггүй, эрх зүйн зохицуулалтыг чанд мөрддөггүйгээс шалтгаалан ТЕЗ-дын түвшинд тухайн онд батлагдсан төсвийн хязгаарыг баримтлахгүй байна.

1.14. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг өмнөх онтой харьцуулж эдийн засгийн ангиллаар авч үзвэл,

Хүснэгт 8. Улсын төсвийн 2019, 2020 оны хөрөнгө оруулалтын харьцуулалт, төсөвт өртөг, санхүүжих дүн, төсөл, арга хэмжээний тоо /тэрбум төгрөг/

Хөрөнгө оруулалтын ангилал		Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль			Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль			Зөрүү нэмэгдсэн +/-, хасагдсан -/-		
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн
Хөрөнгө оруулалт	Шинэ	659	1,621.4	836.6	444	1,543.1	353.2	(215)	(78.3)	(483.4)
	Үргэлжлэх	341	1,240.1	458.8	473	2,054.4	700.8	132	814.3	242.0
Их засвар	Шинэ	165	126.4	114.0	250	122.5	86.5	85	(3.9)	(27.5)
	Үргэлжлэх	27	52.2	25.1	24	58.1	26.9	(3)	5.9	1.8
Тоног төхөөрөмж	Шинэ	72	141.9	107.9	140	120.2	108.8	68	(21.7)	0.9
	Үргэлжлэх	4	11.9	4.7	6	196.4	48.9	2	184.5	44.2
ТЭЗҮ	Шинэ	12	4.6	4.6	10	23.5	5.8	(2)	18.9	1.2
	Үргэлжлэх	1	2.2	1.6	0	0	0	(1)	(2.2)	(1.6)
ДҮН	Шинэ	908	1,894.1	1,063.1	844	1,809.3	554.3	(64)	(84.8)	(508.8)
	Үргэлжлэх	373	1,306.4	490.2	503	2,308.9	776.6	130	1,002.5	286.4
НИЙТ		1281	3,200.5	1,553.3	1347	4,118.2	1,330.9	66	917.7	(222.4)

Эх сурвалж: Монгол Улсын 2019, 2020 оны төсвийн тухай хууль

1.15. Хуульд батлагдсан төсөл, арга хэмжээний 41.6 хувь буюу 554.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 844 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжих, 58.4 хувь буюу 776.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 503 төсөл, арга хэмжээ үргэлжлэн хэрэгжихээр байгааг өмнөх 2019 онтой харьцуулахад шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ 1.08 дахин, санхүүжих дүн 508.8 тэрбум төгрөгөөр буурч, үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээ 1.35 дахин, санхүүжих дүн 286.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн саналд тусаагүй 185 барилга, байгууламжийг Засгийн газар, УИХ-ын хэлэлцүүлгийн үе шатанд нэмж хэрэгжүүлэхээр баталсан байна

1.16. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд 17 ТЕЗ-дын төсвийн багцад 444 барилга, байгууламжийг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас ТЕЗ-дын төсвийн саналд тусаагүй 185 барилга, байгууламжийг Засгийн газар, УИХ-ын хэлэлцүүлгийн үе шатанд нэмж хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 9. ТЕЗ-дын төсвийн саналд үндэслэж төсвийг баталсан байдал /тоо, сая төгрөг/

Д/д	ТЕЗ	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд шинээр батлагдсан барилга, байгууламжийн тоо	Үүнээс,			
			Салбарын бодлого хариуцсан яамны төсвийн саналд туссан		Салбарын бодлого хариуцсан яамны төсвийн саналд тусаагүй	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
1	МУЕС	13	9	69.2	4	30.8
2	МУШС	2	2	100.0	-	-
3	ЗГХЭГД	25	13	52.0	12	48.0
4	БОАЖС	18	9	50.0	9	50.0
5	БХС	1	1	100.0	-	-
6	СаС	4	4	100.0	-	-
7	ХЗДХС	5	4	80.0	1	20.0
8	ХНХС	19	7	36.8	12	63.2
9	БХБС	80	34	42.5	46	57.5
10	БШУС	134	104	77.6	30	22.4
11	СоС	30	21	70.0	9	30.0

12	ЗТХС	42	12	28.6	30	71.4
13	УУХҮС	1	1	100.0	-	-
14	ХХААХҮС	21	1	4.8	20	95.2
15	ЭХС	17	11	64.7	6	35.3
16	ЭМС	28	22	78.6	6	21.4
17	УЕП	4	4	100.0	-	-
Нийт дүн		444	259	58.3	185	41.7

Эх сурвалж: УАГ

1.17. ТЕЗ-дын төсвийн төсөлд тусгагдаагүй барилга, байгууламжийг Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар баталсан нь салбарын бодлого алдагдах, төсөвлөлтийн шаардлага хангагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үр дагавартай байна.

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй 334 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ

1.18. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 23 ТЕЗ-ийн төсвийн багцад батлагдсан 1347 төсөл, арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагатай шинээр хэрэгжүүлэх 405 төсөл, арга хэмжээ байна.

1.19. Үүнээс 17.5 хувь буюу 71 төсөл, арга хэмжээг хуульд тусгахдаа төсөвлөлтийн шаардлагыг хангасан, 66.4 хувь буюу 269 төсөл, арга хэмжээг хуульд хэрэгжилтийг тусгасны дараа зураг төсвийг батлуулсан, 16.1 хувь буюу 65 төсөл, арга хэмжээний зураг төсвийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар батлаагүй байна.

Хүснэгт 10. Шинээр эхлүүлэх ТАХ-ний зураг төсөв баталгаажсан байдал /тоо, эзлэх хувь/

Д/д	ТЕЗ	Зураг, төсөв шаардлагатай шинээр хэрэгжих ТАХ-ний тоо	Үүнээс,		Хуульд тусгасны дараа зураг төсвийг нь батлуулсан ТАХ-ний		Зураг төсвөө батлуулаагүй ТАХ-ний	
			Хуульд тусгахын өмнө зураг, төсвийг нь батлуулсан ТАХ-ний		Хуульд тусгасны дараа зураг төсвийг нь батлуулсан ТАХ-ний		Зураг төсвөө батлуулаагүй ТАХ-ний	
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	МУЕС	13	3	23.1	8	61.5	2	15.4
2	МУШС	2	2	100.0	-	-	-	-
3	ЗГХЭГД	19	1	5.3	11	57.9	7	36.8
4	БОАЖС	18	3	16.7	7	38.9	8	44.4
5	БХС	1	1	100.0	-	-	-	-
6	CaC	3	-	-	-	-	3	100.0
7	ХЗДХС	5	2	40.0	3	60.0	-	-
8	ХНХС	18	1	5.6	13	72.2	4	22.2
9	БХБС	75	8	10.7	67	89.3	-	-
10	БШУС	132	25	18.9	86	65.2	21	15.9
11	СоС	30	4	13.3	21	70.0	5	16.7
12	ЗТХС	42	7	16.7	20	47.6	15	35.7
13	УУХҮС	1	-	-	1	100.0	-	-
14	ХХААХҮС	3	1	33.3	2	66.7	-	-
15	ЭХС	16	1	6.3	15	93.7	-	-
16	ЭМС	23	8	34.8	15	65.2	-	-
17	УЕП	4	4	100.0	-	-	-	-
Нийт дүн		405	71	17.5	269	66.4	65	16.1

Эх сурвалж: УАГ

1.20. Төсвийн тухай хуульд зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталж байгаа нь нэг талаас, төсвийн төлөвлөлтийн зарчим алдагдсан, нөгөө талаас “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНБД 81-94-12/-ийн 4 дүгээр бүлгийн 4.10 дахь хэсэгт “Барилгын нэгдсэн төсвийн тооцоонд зураг төсөл хайгуулын ажлын зардал”-ыг тусгахаар заасантай холбоотой байна.

1.21. Өөрөөр хэлбэл, Зураг төсөл боловсруулж, магадлал хийлгэх үе шатны ажлын зардлыг барилга угсралтын ажлыг гүйцэтгэх үе шатны ажлын төсвийн бүрэлдэхүүнд баталж байгаа нь зураг төсөл боловсруулах үе шатанд санхүүжилт авах боломжгүйд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн нормативт суурилсан төсөвлөлтийг хийгээгүйгээс төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан тохиолдол гарсан байна

1.22. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт стандарт, нормативт суурилсан эсэхийг ерөнхий боловсролын сургуулийн төлөвлөлтөөр жишээ болгон авч үзэхэд дараах байдалтай байна.

1.23. Монгол Улсын сум, дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн барилгын хүчин чадлыг нормативт хэмжээтэй (Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт БД 31-113-11)⁶ харьцуулахад:

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль:

- Барилгын хүчин чадал нормативт хэмжээнээс 159 сум, 4 дүүрэгт хэтэрсэн;
- Барилгын хүчин чадал нормативт хэмжээнээс 24 сум, 5 дүүрэгт доогуур;
- Барилгын хүчин чадал нормативт хэмжээтэй 148 суманд ойролцоо түвшинд байна.



Эх сурвалж: УСХ, УАГ

1.24. Дээрх зураглалаас үзэхэд, нийслэлийн Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүрэг болон нэр бүхий 24 суманд цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөх ерөнхий боловсролын сургуулийн барилгын хэрэгцээ, шаардлага байна.

1.25. Гэтэл Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд нормативт хэмжээгээр ерөнхий боловсролын сургуулийн барилгын хэрэгцээ, шаардлагагүй 9 суманд сургуулийн барилгыг төлөвлөсөн байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 11-ээс харна уу)

⁶ Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн барилгын хүчин чадлыг нормативт хэмжээтэй дараах байдлаар харьцуулсан. Үүнд: Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт БД 31-113-11 дүрмийн 1.3.5-д заасан 1000 хүн тутамд байвал зохих суудлын нормын доод хэмжээ 115 байна гэснийг шалгуур болгон сум, дүүргийн хүн амын тоонд хувааж нормативт суудлын тоог гарган, одоо ашиглагдаж байгаа барилгын хүчин чадалтай харьцуулж тооцоог гаргасан. Мөн ерөнхий боловсролын сургуулийн барилгын хүчин чадал нормативт хэмжээтэй ойролцоо гэдэг нь хүчин чадал ± 100 суудлын дотор хэлбэлзэж байхаар тооцсон болно.

Хүснэгт 11. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд батлагдсан хэрэгцээ, шаардлагагүй ерөнхий боловсролын сургуулийн барилга

Д/д	Байршил		Хүн амын тоо /2020.12.31/	ЕБС-ын хүчин чадал /суудлын тоо/		
	Аймгийн нэр	Сумын нэр		Нормативт хэмжээ	Суурилагдсан хүчин чадал	2020 онд нэмэлтээр төлөвлөсөн
1	Төв	Дэлгэрхаан	1776	205	320	160
2	Архангай	Хайрхан	3718	428	720	320
3	Хэнтий	Өмнөдэлгэр	5890	678	560	640
4	Завхан	Идэр	2529	291	320	320
5	Завхан	Сонгино	1522	175	320	320
6	Увс	Тэс	5181	596	1080	320
7	Хөвсгөл	Их-Уул	4188	482	720	320
8	Архангай	Хашаат	3212	370	640	Өргөтгөл
9	Төв	Заамар	5808	670	860	320


Эх сурвалж: УСХ, УАГ

1.26. Энэ нь орон нутагт ерөнхий боловсролын сургуулийн барилгын ашиглалтгүй талбайг бий болгож төсвийн хөрөнгийг байрны халаалт, урсгал зардалд үр ашиггүй зарцуулахаар байгааг харуулж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хүн амын тоотой бүрэн уялдуулж төлөвлөх шаардлагатай байна

1.27. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд 23 ТЕЗ-ийн төсвийн багцын 1347 төсөл, арга хэмжээнд 1,330.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснийг байршлаар авч үзвэл, 78172 хүн амтай Хэнтий аймагт 103 төсөл, арга хэмжээнд 84.7 тэрбум төгрөг буюу хамгийн их санхүүжилтийг, харин 46981 хүн амтай Дундговь аймагт 22 төсөл, арга хэмжээнд 10.1 тэрбум төгрөг буюу хамгийн бага санхүүжилт төлөвлөснийг хооронд нь харьцуулахад 8.4 дахин зөрүүтэй байна. (Дэлгэрэнгүйг график 3-аас харна уу)

График 3. Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний санхүүжилтийг байршлаар харуулбал



Эх сурвалж: Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

1.28. Мөн Хэнтий аймагт төлөвлөсөн 84.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бусад аймгийн дундажтай харьцуулахад 2.7 дахин их, хүн амын тоогоор 4.3-4.7 дахин их Баянзүрх, Сонгинохайрхан дүүргээс 7.0-8.8 тэрбум төгрөгөөр илүү байгаа нь УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” /хуучин нэрээр/-ын нийгмийн тогтвортой хөгжлийг хангах

зарчимд “нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хүн амын тоотой уялдуулж төлөвлөх”-өөр заасантай нийцэхгүй байна.

1.29. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилт, хүн амын тоотой бүрэн уялдуулахгүйгээр төлөвлөж байгаа нь цаашид нийгмийн тогтвортой хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

Хариуцлагын болон хяналтын тогтолцоо сул байгаагаас төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол буурч байна

1.30. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд 6 буюу түүнээс дээш жил үргэлжлэн хэрэгжиж байгаа 359.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 62.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 43 төсөл, арга хэмжээ байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 12-оос харна уу)

Хүснэгт 12. Улсын төсвийн хөрөнгөөр 6 буюу түүнээс дээш жил санхүүжиж байгаа төсөл, арга хэмжээний дүн

Д/д	Эхэлсэн хугацаа /оноор/	Үргэлжилж байгаа хугацаа /жилээр/	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо
1	2010	10	34.5	4.6	2
2	2011	9	50.7	9.9	6
3	2012	8	116.3	26.2	14
4	2013	7	70.6	10.8	9
5	2014	6	87.2	10.7	12
Нийт			359.3	62.2	43

Эх сурвалж: Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

1.31. Энэ нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болон түүнд олгох санхүүжилтийг төсвийн тухай хуульд батлахдаа барилга, байгууламжийн ажил гүйцэтгэх хугацааны нормд суурилж, нийт төсөвт өртгийг хэрэгжих хугацаанд хувааж нэг жилд ногдох санхүүжилтийг бүрэн тусгадаггүй, хариуцлагагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг, ТЕЗ-даас үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлдэггүй зэргээс шалтгаалж байна.

1.32. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга, байгууламжийн хэрэгжилт удааширснаас төсөвт өртөг нэмэгдэх, тухайн төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол буурах эрсдэлтэй байна.

1.33. Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх барилга, байгууламжийг төлөвлөхдөө барилга, байгууламжийн ажил гүйцэтгэх хугацааны холбогдох норм дүрмийг баримталж, тухайн оны санхүүжилтийг төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаатай уялдуулах, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх хууль, эрх зүйн зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хариуцлага ногдуулах заалтыг холбогдох хуулиар зохицуулах шаардлагатай байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаатай уялдуулж санхүүжилтийг төлөвлөөгүй, мөн төрийн өмчид бүртгэгдэхгүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг зөрчил хэвээр байна

1.34. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэж заасан төсөвлөлтийн зарчмыг хангахгүйгээр санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталж байгаа нь хуулиар тодорхойлсон хугацаанд барилга, байгууламж ашиглалтад орохгүй байх эрсдэлтэй байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (АГГ-2021/06-ШТА-ГА)

Хүснэгт 13. Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан зарим төсөл, арга хэмжээний жишээ /сая төгрөг/

Д/д	ТАХ-ний нэр	Хэрэгжих хугацаа		Батлагдсан		Зөрүү	
		Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	ТАХ-г хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан байх хэмжээ	Тухайн онд баталсан тэнцүү хуваарилсан хэмжээний зөрүү
1	Хүүхдийн эмнэлгийн барилга, 100 ор /Хөвсгөл, Мөрөн сум/	2020	2022	8,700.0	500.0	2,900.0	(2,400.0)
2	Нэгдсэн эмнэлгийн барилга, 300 ор /Архангай, Эрдэнэбулган сум/	2020	2021	17,000.0	500.0	8,500.0	(8,000.0)
3	Дулааны станц /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2020	2021	5,700.0	200.0	2,850.0	(2,650.0)
4	Хануйн голын төмөр бетон гүүр /Архангай, Эрдэнэмандал сум/	2020	2021	3,500.0	500.0	1,750.0	(1,250.0)
5	Орхон голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/	2020	2021	5,500.0	50.0	2,750.0	(2,700.0)
6	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Улаанхус сум/	2020	2021	2,800.0	100.0	1,400.0	(1,300.0)
7	Нисэхийн эцсийн автобусны буудлаас Сонсголгийн төв зам хүртэлх хатуу хучилттай авто зам /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо/	2020	2021	3,200.0	50.0	1,600.0	(1,550.0)
8	"Монгол соёл-Монгол хүмүүн" төсөл хөтөлбөр /Говьсүмбэр/	2020	2021	3,500.0	50.0	1,750.0	(1,700.0)
9	Музейн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2020	2021	5,000.0	50.0	2,500.0	(2,450.0)
10	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 27 дугаар хороо, 45 дугаар цэцэрлэг/	2020	2021	2,500.0	50.0	1,250.0	(1,200.0)
11	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2020	2021	2,800.0	50.0	1,400.0	(1,350.0)
12	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо/	2020	2021	2,200.0	50.0	1,100.0	(1,050.0)
13	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	2020	2021	2,500.0	50.0	1,250.0	(1,200.0)
14	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, 14 дүгээр сургууль/	2020	2021	3,800.0	50.0	1,900.0	(1,850.0)
Нийт				68,700.0	2,250.0	32,900.0	(30,650.0)

Эх сурвалж: Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

1.35. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар БХБС-ын төсвийн багцад хөрөнгө оруулалтын бус шинжтэй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй зарим төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн нь төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг алдагдуулсан байна.

Хүснэгт 14. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бус шинжтэй зарим төсөл, арга хэмжээний жагсаалт /сая төгрөг/

Д/д	ТАХ-ний нэр	Төрөл	Хугацаа		Төсөвт өртөг
			Эхлэх	Дуусах	
1	Насжилт өндөртэй орон сууцны байруудын дээврийн их засвар /УБ, БЗД, 4, 5, 14 дүгээр хороо/	Их засвар	2019	2020	2,200.0

2	Орон сууцны байруудын гадна фасад, дээврийн их засвар /Сэлэнгэ, Сайхан сум, 1, 3, 4, 8, 11, 14, 15, 16, 17, 18, 19, 23, 24 дүгээр байр/	Их засвар	2019	2020	1,752.0
3	Орон сууцны байруудын их засвар /Улаанбаатар, Багахангай дүүрэг, 1 дүгээр хороо/	Их засвар	2019	2020	3,886.1
4	3 дугаар 60 айлын дээврийн засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Ганзамын 7 дугаар баг/	Их засвар	2020	2020	48.0
5	Нийтийн орон сууцны гадна фасад /Хэнтий, Бор-Өндөр сум/	Их засвар	2020	2021	550.0
6	Нийтийн орон сууцны засвар, шинэчлэл /Дархан-Уул, Дархан сум, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар баг/	Их засвар	2020	2020	990.0
7	Нийтийн эзэмшлийн байруудын фасадын засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	Их засвар	2020	2020	610.0
8	Нийтийн эзэмшлийн байрын гадна фасад /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо/	Их засвар	2020	2020	250.0
9	Нийтийн эзэмшлийн байрын дээвэр, фасадын засвар, 36 айл /Ховд, Жаргалант сум, Рашаант баг/	Их засвар	2020	2021	140.0
10	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын гадна фасад, дулаалгын засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	Их засвар	2020	2021	1,330.0
11	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дээврийн засвар /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	Их засвар	2020	2021	830.0
12	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 10 дугаар хороо/	Их засвар	2020	2021	400.0
13	Орон сууцны гадна фасадын засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 10 дугаар хороо/	Их засвар	2020	2021	1,000.0
Нийт					13,986.1

Эх сурвалж: Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд өмнөх оноос үргэлжлэх төсөл, арга хэмжээнд хангалттай хөрөнгө төсөвлөөгүйгээс дуусаагүй, орхигдсон барилга нэмэгдэх эрсдэл байна

1.36. Өмнөх онуудад эхлүүлж он дамжин үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр хуульчилсан 64.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд тусгахгүйгээр орхигдуулсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, дуусаагүй орхигдсон барилга нэмэгдэх үр дагавартай байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу)

1.37. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар баталсан 178.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 26 төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд тусгахдаа төсөвт өртгийг нийт 185.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлжээ.

1.38. Төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний 11 буюу 42.3 хувь нь нэмэлт ажил гарснаас, 3 буюу 11.5 хувь нь хуульд зураг төсөвгүй туссанаас, 1 буюу 3.8 хувь нь төсвийн үнэлгээ нэмэгдсэнээс, 2 буюу 7.7 хувь нь хуульд иж бүрэн зураг төсөвгүй туссанаас, 9 буюу 34.6 хувь нь бусад асуудлаас тус тус шалтгаалсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу)

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системийг 2020 оны төсвийн төлөвлөлтөд хэрэгжүүлсэн ч төслүүдийг батлах үе шатанд системээр төлөвлөөгүй төслүүдийг тусгасан нь үр ашиггүй төсөл, арга хэмжээ хэрэгжих үр дагавартай байна

1.39. Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn цахим хуудас болон гар утасны аппликейшн зэргийг ашиглалтад оруулж санхүүжилтийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах алхам болсон байна.

1.40. Дээрх арга хэмжээний эрх зүйн орчныг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга

хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”, 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-аар бүрдүүлсэн байна.

1.41. Гэвч Монгол Улсад хариуцлагын тогтолцоо сул байгаагаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хууль, эрх зүйн зохицуулалт зөрчигдөж, цахим системийн шаардлагын дагуу төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагаа бүрэн хийгдээгүй нь үр ашиггүй төсөл, арга хэмжээ хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж байна.

1.42. Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарсан ашиглалтын шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг шинээр төлөвлөхөөс илүүтэй их засварын санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгөөр төсөвлөсөн нь оновчгүй байна. Тухайлбал,

- Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 08-07-033/06/12 дугаар бүхий “Барилгын ашиглалтын тухай” дүгнэлтээр “2 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж газрыг дахин төлөвлөлтөд оруулах нь зүйтэй” гэсэн байна. Гэтэл аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсээс тус цэцэрлэгт засвар хийх төсвийн төсөл хүргээгүй байхад БШУС-ын багцаас 60.0 сая төгрөгийн засварын зардал батлагдан, аймагт эрх шилжин ирснээр засвар хийгдсэн байна.
- Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсээс 6 дугаар цэцэрлэгт засвар хийх талаар төсвийн төсөл хүргээгүй байхад БШУС-ын багцаас их засвар хийхээр 46.0 сая төгрөгийн төсөв батлагдан, аймагт эрх шилжин ирснээр засвар хийгдсэн байна. Гэтэл Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 08-07-033/10 дугаар бүхий “Барилгын ашиглалтын тухай” дүгнэлтээр “6 дугаар цэцэрлэгийн барилга ашиглалтад орсноос хойш 54 жил ашиглагдаж, ашиглалтын хугацааны аюулгүй байдлыг хангахгүй болсон тул барилгад үйл ажиллагаа явуулахгүй байх нь зүйтэй” гэсэн байна.
- Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 08-07-033/08/119 дугаар бүхий “Барилгын ашиглалтын тухай” дүгнэлтээр “Хуучин Алтай чуулгын барилгыг буулгаж газрыг дахин төлөвлөлтөд оруулах нь зүйтэй” гэсэн байна. Гэтэл БШУЯ-ны багцаас 830.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Алтай” чуулгын хуучин барилгыг “Багшийн хөгжлийн ордон” болгож өөрчлөх арга хэмжээний хүрээнд 2020 онд 50.0 сая төгрөгийг батлан, аймагт эрх шилжин ирснээр хэрэгжиж эхлээд байна.

1.43. Төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй буюу газрын зөвшөөрөл гараагүй, техникийн нөхцөл олгогдоогүй байхад зарим төсөл, арга хэмжээг хуульд тусгасан нь тайлант онд бүрэн хэрэгжүүлэх боломжгүй, хэрэгжилт удаашрахад хүргэсэн байна. Тухайлбал,

Газрын зөвшөөрөл олгогдоогүй ТАХ-ний тухайд:

- Архангай аймагт байршилтай 6 ТАХ;
- Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/;
- Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/;
- Ховд аймгийн Буянт сумын Цагаан эрэг багийн барилга, Дуут сумын төвийн гэрэлтүүлэг, Жаргалант сумын Хүүхдийн тоглоомын талбай зэрэг ажлуудын газрын зөвшөөрлийн асуудлыг хугацаа алдаж шийдвэрлэсэн;
- Говь-Алтай аймгийн Тонхил сумын спорт заалны барилга, Есөнбулаг сумын 8 багт хүүхдийн тоглоомын талбай, Дэлгэр сумын сургууль, цэцэрлэгийн барилгын дэд бүтэц, халаалтын зуух, Есөнбулаг сумын нийтийн тээврийн автобусны буудал.

Техникийн нөхцөл олгогдоогүй ТАХ-ний тухайд:

- Архангай аймагт байршилтай 4 ТАХ;
- Орхон аймагт байршилтай 8 ТАХ;
- Нийслэлд 2,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Агро паркийн эко сургалтын төвийн барилга, 300 суудал /УБ, БГД, 20 дугаар хороо/ ТАХ-ний цэцэрлэгт хүрээлэн, мод үржүүлгийн зориулалттай газрын зориулалтыг өөрчлөн, архитектур төлөвлөлтийг зөвшөөрлөх боломжтой түр барилга хэлбэрээр төлөвлөсөн байна. Тус барилга нь БОАЖС, БХБС-ын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-ын 3.95 дахь заалтыг зөрчин баригдсан тул холбогдох газраас ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбох техникийн нөхцөлийг олгоогүй байна.
- Дархан-Уул аймагт Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн хөл бөмбөгийн иж бүрэн талбай, тохижилт, Тосгон чиглэлийн гадна дулааны шугам, Сургуулийн 480 суудалтай барилга,

Цэцэрлэгийн 100 ортой барилга ТАХ-ний техникийн нөхцөлийг хуульд батлагдсаны дараа олгосон байна.

- *Говь-Алтай аймгийн Тонхил сумын спорт заалны барилга, Ахмадын холбоо, сувиллын барилга, Дарив сумын сургууль, цэцэрлэгийн дэд бүтэц, уурын зуух, Есөнбулаг сумын 8 багт хүүхдийн тоглоомын талбай, Бугат сумын цэвэр усны шугам сүлжээний шинэчлэлт, Дэлгэр сумын сургууль, цэцэрлэгийн барилгын дэд бүтэц, халаалтын зуух, Есөнбулаг сумын нийтийн тээврийн автобусны буудал.*
- *Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Соёлын төвийн барилга, 240 суудал.*

Инженер геологийн дүгнэлт гараагүй ТАХ-ний тухайд:

- *Говь-Алтай аймгийн Тонхил сумын спорт заалны барилга, Ахмадын холбоо, сувиллын барилга, Дарив сумын сургууль, цэцэрлэгийн дэд бүтэц, уурын зуух, Есөнбулаг сумын 8 багт хүүхдийн тоглоомын талбай, Бугат сумын цэвэр усны шугам сүлжээний шинэчлэлт, Дэлгэр сумын сургууль, цэцэрлэгийн барилгын дэд бүтэц, халаалтын зуух, Цээл сумын цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух, Есөнбулаг сумын нийтийн тээврийн автобусны буудал.*
- *Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын цаг уурын өртөөний барилга, Мөрөн сумын 10, 11, 12, 13, 14 дүгээр багийн ахмадын өргөөний барилга, Мөрөн сумын 1, 2, 3, 4, 6 дугаар багийн гэр хорооллын хөрсний бохирдлыг багасгах эко ариун цэврийн байгууламж хөтөлбөр.*

1.44. Дээрх байдлаас үзэхэд, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвлөлтийн талаарх хууль тогтоох болон төрийн байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй, эрх зүйн чадамж, хариуцлага тооцох асуудал сул байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо алдагдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ БҮРЭН ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСНААС ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДЭХ, ХЭРЭГЖИЛТ УДААШРАХ, ҮР АШИГГҮЙ ЗАРДАЛ ГАРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА

Худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулаагүйгээс төсөл, арга хэмжээний гүйцэтгэл тайлант онд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүсжээ

2.1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд 23 ТЕЗ-ийн төсвийн багцад 1,809.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 552.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 844 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна.

2.2. Засгийн газрын 2020 оны 21 дүгээр тогтоолоор улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар Төрийн худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг нь зохион байгуулах шинээр хэрэгжих 388.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 171.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 187 төсөл, арга хэмжээний жагсаалтыг нэгдүгээр, аймаг, нийслэл худалдан авах ажиллагааг нь зохион байгуулах 408.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 212.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 600 төсөл, арга хэмжээний жагсаалтыг хоёрдугаар, Ерөнхий гэрээгээр худалдан авах 3 төсөл, арга хэмжээний жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсан байна.


2.3. Уг тогтоолд 2019 оноос үргэлжлэн хэрэгжих 47.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 19.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 9 төсөл, арга хэмжээ нэгдүгээр хавсралтаар баталсан жагсаалтад, 2.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 0.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 2 төсөл, арга хэмжээ хоёрдугаар хавсралтаар баталсан жагсаалтад тусгагдсан байна.

2.4. Засгийн газрын 2020 оны 21 дүгээр тогтоолоор эрх шилжүүлээгүй 168.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 57 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТЕЗ-д зохион байгуулсан байна.

2.5. Тайлант хугацаанд шинээр хэрэгжүүлэх 844 төсөл, арга хэмжээний 667 буюу 79.0 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 137 буюу 16.2 хувийг тендер шалгаруулалтын онцгой журмаар зохион байгуулж, 9 буюу 1.1 хувийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар, 31 буюу 3.7 хувь нь ямар журмаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан талаар цахим системд мэдээлэл оруулаагүй байна.

2.6. Худалдан авах ажиллагааг зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа 777 төсөл, арга хэмжээ буюу 93.1 хувийг цахимаар зохион байгуулжээ.

График 4. ТЕЗ-дын худалдан авах ажиллагаа зохион байгуулсан хугацаа /хувь, сараар/



Эх сурвалж: Сангийн яам

2.7. Тайлант хугацаанд ТЕЗ-дын худалдан авах ажиллагааны хугацааг сараар авч үзвэл, 2020 оны эхний хагас жилд 82.2 хувь нь, сүүлийн хагас жилд 17.8 хувь нь зохион байгуулагдсан байна.

2.8. ТЕЗ-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 17.8 хувийг сүүлийн хагас жилд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8-д “барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх” гэж заасныг зөрчиж, төсөл, арга хэмжээ тайлант онд бүрэн хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.9. Мөн 2020 онд тендер шалгаруулалттай холбоотой 1271 гомдол гарсан бөгөөд үүнээс 154 гомдол буюу 12.1 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, 1009 гомдол буюу 79.4 хувь нь захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр Сангийн яаманд, 108 гомдол буюу 8.5 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсвэл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр Захиргааны хэргийн шүүхэд тус тус хандсан байна.

2.10. Сангийн яам 816 тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбогдуулан 560 аж, ахуй нэгжээс давхардсан тоогоор нийт 1009 гомдлыг хянан шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй 134 гомдол буюу 13.3 хувь;
- Үнэлгээг дахин хийлгэх 590 гомдол буюу 58.5 хувь;
- Тендер шалгаруулалтыг хүчингүй болгох 71 шийдвэр буюу 7.0 хувь;
- Захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг тендерт оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулсан 214 гомдол буюу 21.2 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагчдад Сангийн яамнаас өгсөн дундаж үнэлгээ 74.7 хувьтай байна

2.11. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт заасны дагуу Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн /уг журам Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар хүчингүй болсон/ Сангийн яамнаас ТЕЗ-дын 2020 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн төлөвлөгөө, тендер шалгаруулалтын явц, цахим тендер шалгаруулалтын урилга, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн үнэлгээ өгсөн байна.

Хүснэгт 15. ТЕЗ нарын худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээ /хувиар/

Д/д	ТЕЗ	Худалдан авах ажиллагааны үнэлгээ 2020 оны					Д/д	ТЕЗ	Худалдан авах ажиллагааны үнэлгээ 2020 оны				
		2017 он	2018 он	2019 он	хувь	үнэлгээ			2017 он	2018 он	2019 он	хувь	үнэлгээ
1	ХЗДХС	84.3	86.0	81.0	88.0	сайн	13	ЭХС	68.9	58.8	71.0	71.0	хангалттай
2	ҮСХД	61.4	71.6	49.0	88.0	сайн	14	БШУС	60.0	52.2	43.0	71.0	хангалттай
3	АТГД	**	81.0	80.0	87.0	сайн	15	МУЕС	75.0	83.8	70.0	70.0	хангалттай
4	СаС	73.8	75.5	70.0	87.0	сайн	16	ЭМС	68.8	71.6	77.0	67.0	хангалттай
5	ЗГХЭГД	77.1	82.7	78.0	86.0	сайн	17	МУШС	75.0	74.4	80.0	63.0	хангалттай
6	ҮХЦД	**	71.6	60.0	85.0	сайн	18	ХНХС	69.1	58.9	60.0	62.0	хангалттай
7	УЕП	41.7	63.5	74.0	83.0	сайн	19	ЗТХС	92.0	81.6	67.0	61.0	хангалттай
8	БХС	60.0	82.3	80.0	81.0	сайн	20	БОАЖС	72.5	73.3	84.0	60.0	хангалттай
9	МУЕА	0.0	60.0	60.0	80.0	сайн	21	БХБС	59.6	48.5	79.0	51.0	хангалтгүй
10	ХХААХҮС	72.5	67.0	84.0	77.0	хангалттай	22	МУИХД	60.0	**	**	0	
11	УУХҮС	84.8	73.3	71.0	77.0	хангалттай	23	СоС	-	-	-	-	
12	ГХС	58.1	63.7	68.0	73.0	хангалттай							
		Дундаж хувь							69.2	70.5	70.8	74.7	

Эх сурвалж: Сангийн яам

** - худалдан авалт байхгүй,
0 - тайлан ирүүлээгүй

2.12. Сангийн яамнаас 23 ТЕЗ-ийн улсын төсвийн хөрөнгөөр зохион байгуулсан худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ өгөхөд 9 нь сайн буюу 80-88 хувь, 11 нь хангалттай буюу 60-77 хувь, 1 нь хангалтгүй буюу 51 хувийн үнэлгээ авч дунджаар 74.7 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад үнэлгээний түвшин 3.9 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад ТБОНӨХБАҮХАТХ болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийн зохицуулалт зөрчигдсөөр байна

2.13. ТЕЗ-даас орон нутагт эрх шилжүүлэхдээ Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах журам”-ын 2.13⁷ дахь хэсэгт заасныг зөрчиж хугацааг хэтрүүлснээс худалдан авах ажиллагаанд хугацаа алдаж, хэрэгжилт удааширсан байна. Тухайлбал,

Баян-Өлгий аймагт: 5 ТЕЗ-аас 23 ТАХ-ний эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлэхдээ холбогдох журамд заасан хугацаанаас 22-32 хоног хэтрүүлсэн;

Хэнтий аймагт: БСШУСС-аас 86-110 хоног, ХНХС-аас 93 хоногоор хэтрүүлж Засаг даргад эрх шилжүүлсэн;

Нийслэлд: ТЕЗ-даас 152.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 197 ТАХ-ний эрхийг НЗД-д шилжүүлэхдээ 5-212 хоногийн хугацаагаар хоцроосон байна.

Дорнод аймагт: Хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр хэрэгжүүлэх 18 төсөл, арга хэмжээг 10-30 хоногоор хугацаа хоцроож шилжүүлсэн байна.

Хөвсгөл аймагт: Хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 8-203 хоногоор хугацаа хоцроож шилжүүлсэн байна.

2.14. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороог төлөвлөгөөнд заасан хугацаанаас хоцроож байгуулснаас худалдан авах ажиллагаанд хугацаа алдах эрсдэл үүссэн байна. Тухайлбал,

Хэнтий аймагт:

- Нийт 68 үнэлгээний хороо байгуулснаас 66-г худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанаас 3-117 хоногоор хоцроосон;

Увс аймагт:

- Үнэлгээний хороо байгуулахаар төлөвлөсөн хугацааг нийт 61 ТАХ-нд 3-154 хоногоор хоцроосон;

- Тендер зарлах хугацааг нийт 61 ТАХ-нд 7-74 хоногоор хоцроосон;

- Гэрээ байгуулах эрх олгох хугацааг нийт 61 ТАХ-нд 2-196 хоногоор хоцроосон байна.

БСШУСС /хуучин нэрээр/:

- БСШУСС /хуучин нэрээр/-ын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/811 дүгээр тушаалаар 2020 оны төсвийн тухай хуульд шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Төлөвлөгөөнд 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр үнэлгээний хороо байгуулахаар төлөвлөсөн ч энэ хугацаанаас 44-238 хоногийн дараа үнэлгээний хороо байгуулан тендер зарласан байна.

2.15. Орон нутагт эрх шилжүүлсэн шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үнэлгээний хороо, худалдан авах ажиллагаа, гэрээ байгуулах зэрэгт хугацаа алдсанаас хэрэгжилт удаашрах, он дамжин хэрэгжих үр дагавар үүссэн байна. Тухайлбал,

Архангай аймагт: “Аймгийн Соёлын төвүүд, хөгжимт драмын театрт цахилгаан хөгжмийн тоног төхөөрөмж худалдан авах”, “Өндөр-Улаан сумын сургуульд тоног төхөөрөмж худалдан авах”, “Хангай сумын ЕБС-д тоног төхөөрөмж нийлүүлэх” ТАХ-ний ХАА-г хугацаа алдаж зохион байгуулснаас он дамжсан;

Дундговь аймагт: 8 ТАХ-ний ХАА-г төлөвлөснөөс 5-20 хоног, 3 ТАХ-ний ХАА-г төлөвлөснөөс 21-100 хоног тус тус хэтрүүлснээс хэрэгжилт удааширсан;

⁷ Захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх

Орхон аймагт: 5 ТАХ-ний үнэлгээний хороог 14 хоног, 9 ТАХ-ний ХАА-г төлөвлөснөөс 8-60 хоног, 9 ТАХ-ний гэрээ байгуулах явц 13-64 хоногоор хэтрүүлсэн.

Баян-Өлгий аймагт: ХАА зохион байгуулах 11 ТАХ-ний зураг төсөл хийгдээгүйгээс төлөвлөсөн хугацаанаас 53-140 хоногоор хожимдож зарласан;

Нийслэлд: Үнэлгээний хороод байгуулагдах ч газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт болон холбогдох баримт материал дутуу, боловсруулагдаагүй зэргээс шалтгаалан 28 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж эхлэхэд 30-60 хүртэл хоног, 34 ТАХ 63- 273 хоногийн хугацаа алдсан байна.

Өвөрхангай аймагт: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 5 төсөл, арга хэмжээний үнэлгээний хороо байгуулах хугацааг төлөвлөснөөс 5-135 хоног, 17 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах эрх олгох хугацааг 8-138 хоног, 16 төсөл арга хэмжээний гэрээ байгуулах хугацааг 3-30 хоног хэтрүүлсэн байна.

Дархан-Уул аймагт: Захиалагчаас тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай тендерийн холбогдох материалыг хугацаанд нь ирүүлээгүйгээс үнэлгээний хороог, эрх шилжүүлсэн хугацаанаас 62-135 хоногийн дараа байгуулсан байна.

2.16. Орон нутагт эрх шилжүүлсэн шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн баримт бичиггүйгээр болон тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.3 дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал,

Архангай аймагт:

- Жаргалант, Булган, Чулуут сумын соёлын төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Газрын гагнаас” ХХК болон “Эсгэл” ХХК-ийн голлох инженер, техникийн ажилтнуудын НДШ төлөлт хангалтгүй, ТШӨХ-ийн шаардлагыг хангаагүй;
- Өндөр-Улаан сумын Хануйн бага сургуулийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Тамир таун” ХХК, “Эсгэл” ХХК-ийн түншлэлийн инженер, техникийн ажилтнууд ТШӨХ-ийн шаардлагыг хангаагүй;
- Хашаат сумын сургуулийн дотуур байрны өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр шалгарсан “Тамир таун” ХХК, “Эсгэл” ХХК-ийн түншлэлийн голлох инженер, техникийн ажилтнууд мөн адил ТШӨХ-ийн шаардлагыг хангаагүй;
- Сумдын ерөнхий боловсролын сургуульд сурагчийн ширээ, сандал нийлүүлэх 3 багц бүхий тендерийн 2, 3 дугаар багцад “Баялаг заваг” ХХК-ийн борлуулалтын орлого ТШӨХ-ийн шаардлагыг хангаагүй байхад дотоодын давуу эрх тооцож шалгаруулсан;
- Малын цахим бүртгэлийн систем худалдан авах тендерийн 1 дүгээр багцад шалгарсан “Ногоон алт консалтинг” ХХК 2018 онд ашигтай ажиллаагүй, 2018, 2019 оны санхүүгийн тайлан аудитлагдаагүй, 2 дугаар багцад шалгарсан “Атгамал” ХХК-ийн 2018, 2019 оны санхүүгийн тайлан аудитлагдаагүй ТШӨХ-ийн шаардлагыг хангаагүй.

Нийслэлд:

- СХД-ийн ХААА-аас Сургуулийн дотуур байрны барилга, 70 ор /УБ, СХД, 21 дүгээр хороо/ ТАХ-ний гүйцэтгэгч “Морин сувд” ХХК-ийг Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан зураг төсөв боловсруулах байгууллагын тусгай зөвшөөрлийн хавсралтыг ирүүлэх тусгай шаардлагыг хангаагүй байхад сонгон шалгаруулсан.
- Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан санхүү, боловсон хүчин, техникийн чадавх, тоног төхөөрөмж, туршлагын шалгуур хангаагүй 5,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ сонгон шалгаруулсан байна

Өвөрхангай аймагт:

- Шинээр ашиглалтад орох боловсрол, соёл, спортын байгууллагуудад тавилга, тоног төхөөрөмж худалдан авах 500.0 сая, Боловсрол, соёлын салбарын байгууллагуудын тоног төхөөрөмж 500.0 сая, Боловсрол, соёлын салбарын байгууллагуудын тоног төхөөрөмж худалдан авах 500.0 сая, Боловсрол, соёл, спортын салбарын их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэл /Арвайхээр, Тарагт сум/ 500.0 сая төгрөг, Боловсрол, соёлын салбарын их засвар /Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан сум/ 500.0 сая, Худаг шинээр барих 600.0 сая, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн 300.0 сая, Сумын төвийн үерийн усны далан шуудуу /Уянга сум/ 1,500.0 сая, Багийн төвийн барилга /Баянгол, Богд сум/ 140.0 сая, Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Есөнзүйл сум/ 200.0 сая, Сургуулийн дотуур байрны засвар /Баян-Өндөр сум/ 30.0 сая, Багийн төвийн мал угаалгын ванн, талбай /Бат-Өлзий, Хархорин, Хужирт,

Уянга, Зүүнбаян-Улаан сум/ 300.0 сая, Төрийн захиргааны байгууллагуудын тоног төхөөрөмж /Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан сум/ 200.0 сая, Аймгийн цагдаагийн газрын хуучин барилгын засвар 200.0 сая, Сумын төвийн гэрэлтүүлэг, тохижилт /Хархорин сум/ 500.0 сая, Усан сан /Баянгол сум/ 80.0 сая, Усан хангамж, шугам сүлжээ /Сант сум/ 250.0 сая төгрөгийн ажлуудын ХАА-а хуульд нийцэж боловсруулагдаагүй тендерийн баримт бичгээр зохион байгуулсан байна.

Говьсүмбэр аймагт:

- БСШУСС-ын багцаас эрх шилжсэн 33.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Усан спорт сургалтын барилгын сантехникийн засвар”-ын ажлын техникийн тодорхойлолтыг цахилгааны болон дээврийн ажил болгон өөрчилж, ажлын тоо хэмжээнд БТСГ-ын дээврийн хэсэгчилсэн засварыг нэмж зориулалтыг өөрчилсөн.

Дорнод аймагт:

- “Бага сургууль, дунд, ахлах сургуулийн хичээлийн байрны дээврийн засвар” /Дорнод, Хэрлэн сум, 8-р сургууль/-ын ажилд үнийн санал ирүүлсэн “Дорнод хийц” ХХК-ийн тендерийн материалд барилгын тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралт байхгүй, ТШӨХ-ийн ТООЗ-ны 2.38-д заасан шаардлагыг хангаагүй байхад шалгаруулсан.
- “Бага сургуулийн өргөтгөлийн барилгын их засвар” /Дорнод, Хэрлэн сум, 1, 5 дугаар сургууль/-ийн ажилд үнийн санал ирүүлсэн “ДОЦ” ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТООЗ-ны 4.4.(в)9-д заасан шаардлагыг хангаагүй байхад шалгаруулсан.
- “Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар” /Дорнод, Чулуунхороот сум/-ийн ажилд үнийн санал ирүүлсэн “Донж Өргөө” ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТООЗ-ны 4.4.(в)10-д заасан шаардлагыг хангаагүй байхад шалгаруулсан.
- “Дотуур байрны барилгын их засвар” /Булган сум/-ийн ажилд үнийн санал ирүүлсэн “Бүжнэр” ХХК тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн ТООЗ-ны 1.111-д заасан шаардлагыг хангаагүй байхад шалгаруулсан байна.

2.17. Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг боловсруулахдаа жишиг баримт бичигт нийцүүлээгүй, зарим нөхцөлийг орхигдуулж гэрээ байгуулснаас хариуцлага тооцох боломжгүйд хүрсэн байна. Тухайлбал,

Баян-Өлгий аймагт:

- Баяннуур сумын сургуулийн хичээлийн байрны 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй А корпус, спорт заалны их засварын ажлыг гүйцэтгэгч “Нармаржан” ХХК ажил гүйцэтгэх гэрээг хоёр удаа сунгуулсан боловч их засварын ажлыг өнөөг хүртэл дуусгаагүй байна. Үнэлгээний хорооны боловсруулсан тендерийн бичиг баримтад гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд авах арга хэмжээ, хариуцлага, алдангийн талаар тусгаагүйгээс гүйцэтгэгч компанид хариуцлага тооцох боломжгүй байна.

Ховд аймагт:

- Сум, багийн хөгжлийг дэмжих төслөөр Жаргалант сумын Баатархайрхан, Бичигт, Наран, Тахилт баг, Алтай, Буянт, Манхан, Мөст, Үенч сумдад хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн 300.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний ажлын даалгавар тодорхой бус, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулагдаагүй байна.

2.18. ТБОНӨХБАҮХАТХ болон түүнд нийцүүлэн гарсан журмыг мөрдөхгүйгээр худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна. Тухайлбал,

Өвөрхангай аймагт:

- Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Арвайхээр сум/ барих 1,500.0 сая төгрөгийн төсөвтэй ажлын тендерт шалгарсан “Сод-Ээл” ХХК нь мэргэжилтэй инженер техникийн ажилтны хувьд илэрхий чадамжгүй /Тухайлбал, ерөнхий инженер

⁸ “Баталгаажуулсан” гэдэгт сүүлийн 6 сарын дотор нотариатаар баталгаажуулсныг ойлгоно;

⁹ Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: Шаардлагатай. Үүнд: БА-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт, БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт,

¹⁰ Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: Шаардлагатай. Үүнд: БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт, БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер орчны тохижилтын ажил,

¹¹ Тендерт оролцогч дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: БА-6.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил, БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,

Батсайхан нь тухайн компанид ажилд орсон тушаалын бичилт байхгүй, 2018 онд ажиллаагүй, мэргэжлийг нотлох баримт байхгүй, инженер Н.Лонжид нь мэргэжлээрээ 5 жил ажилласан байх болзлыг хангаагүй, сантехникийн инженер Б.Чулуунтогтох нь мэргэжлийн болон мэргэжлээрээ ажилласан хугацааны шаардлага хангаагүй, цахилгааны инженер Ц.Отгонбямба, С.Ганхүлэг, сантехникийн инженер О.Төмөр нар нь шаардагдаж буй мэргэжлийн бус бөгөөд тус компанийн үндсэн ажилтан байх шаардлагыг хангаагүй/ байхад уг тендерт шалгаруулсан байгаа нь ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн байна. Түүнчлэн “Сод-Ээл” ХХК нь Эрчим хүчний яамны 03.2.1 тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй байна.

- Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Арвайхээр сум/ барих 3,500.0 сая төгрөгийн төсөвтэй ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Воконстракшн” ХХК-ийн инженерүүдийн дэвтрийн дугаар засвартай, хуудас бүрд дугаар бичигдээгүй учир нийгмийн даатгалын шимтгэл төлж ажиллаагүй гэж үзсэн боловч бүгд төлж ажилласан нь дэвтрийн бичилт, нийгмийн даатгалын тайлангаар батлагдаж байна. Мөн тендерийн бичиг баримтад урьд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлыг хүлээн авсан актаар нотолно гэсэн боловч улсын комиссын акт байсаар байхад ашиглагчийн тодорхойлолтыг гараар бичсэн гэсэн үндэслэлээр нотлогдоогүй гэж үзжээ. Харин санал өгсөн үнийн хэмжээгээр гуравдугаарт эрэмбэлэгдсэн “Бианконэро констракшн” ХХК-ийн инженер Бат-Орших, Цэрэнхүү нар нь 2018 онд ажиллаж байгаагүй, гурван инженерийн дэвтэр мөн хуудсандаа дугааргүй байхад зөрчил гэж үзэхгүйгээр тус тендерт шалгаруулжээ.
- Багийн төвийн мал угаалгын ванн, талбай /Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан сум/ 300.0 сая төгрөгийн төсөвтэй тендерийн 120.0 сая төгрөгийн төсөвтэй 1 дүгээр багцад хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Девсофт” ХХК /103.0 сая төгрөг/, “Кенорда” ХХК /105.0 сая төгрөг/-ийн тендерийг огт үнэлж хэлэлцэхгүйгээр татгалзаж, 108.8 сая төгрөгийн санал ирүүлсэн “Баяжих Ундарга” ХХК-ийг шалгаруулсан бол 90.0 сая төгрөгийн төсөвтэй 3 дугаар багцад “Амадо” ХХК 84.0 сая төгрөгийн үнэ санал болгосон байхад хөнгөлөлтийг тооцоод 85.3 сая төгрөгийн үнэ ирүүлсэн “Монгол менежмент” ХХК-ийг шалгаруулжээ. Эдгээр 3 багц тендерийг үнэлж хэлэлцсэн тэмдэглэл байхгүй, үнэлгээний хорооны нарийн бичгийн даргын шууд санал болгосноор шалгаруулалтыг хийсэн байна.

2.19. Төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд баталснаас дутуу төсвөөр болон зураг төсөлгүйгээр худалдан авах ажиллагааг зарлаж байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал,

Хэнтий аймагт:

- Аварга нуурын зүүн бүрдийг сэргээх /Хэнтий, Дэлгэрхаан сум/, Сумын төвийн гадна цэвэр усны шугам /Хэнтий, Батноров сум/, Сумын төвийн гадна цэвэр усны шугам сүлжээ /Хэнтий, Жаргалтхаан сум/ гэсэн 3 ТАХ-ний тендерийг зураг төсөлгүйгээр зарласан;
- Нийт 22 ТАХ-ний тендерийн үнэ магадлалаар баталгаажсан төсвийн дүнгээс 4.5 тэрбум төгрөгөөр доогуур байна.

Өвөрхангай аймагт:

- Бат-Өлзий сумын ЗДТГ-ын барилгын их засвар, өргөтгөл барих зураг батлагдаагүй байхад 2019 онд тендер зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулсан. Гэтэл уг өргөтгөлийн барилга нь хэрэглэгчийн болон чанарын шаардлагыг хангахгүй байгаагаас 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар тус барилгын өргөтгөл, их засварын ажлыг ашиглалтад хүлээн аваагүй байна.

2.20. Захиалагч Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсгийг зөрчиж бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор чанарын баталгааны төлбөрийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй байна. Тухайлбал,

ХХААХҮЯ:

- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн хуучин барилгын их засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ-ний чанарын баталгааны 20.1 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй.

Магадлалаар баталгаажуулсан төсөвт өртгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас үр ашиггүй зардал гарах эрсдэлийг үүсгэсэн байна

2.21. Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан 8 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон ажил гүйцэтгэх гэрээний дүнгээс магадлалаар баталгаажсан төсвийн дүн 1,020.9 сая төгрөгөөр бага байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас харна уу)

2.22. Энэ нь төсөл, арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөвгүйгээр, тойм дүнгээр төсөвт өртгийг баталж худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас шалтгаалсан бөгөөд цаашид улсын төсвөөс үр ашиггүй зардал гарах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлжээ.

2.23. Иймд харьяалах ТЕЗ нар болон Сангийн яам төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, гэрээний дүнг магадлалаар баталгаажсан төсвийн дүнтэй уялдуулан хянаж, зохион байгуулалтын арга хэмжээг авах зайлшгүй шаардлага үүссэн байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт бодит гүйцэтгэлээр 78.4 хувьтай байна

2.24. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 23 ТЕЗ-ийн төсвийн багцад 4,118.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,330.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1347 төсөл, арга хэмжээнд олгосон санхүүжилтийн гүйцэтгэл 1,093.6 тэрбум төгрөг буюу 82.2 хувь, зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 237.3 тэрбум төгрөг буюу 17.8 хувьтай гэж Сангийн яамнаас тайлагнасан байна.

2.25. Аудитаар санхүүжилтийн гүйцэтгэлийг хянаж үзэхэд 1,043.2 тэрбум төгрөг буюу 78.4 хувийг бодит ажлын гүйцэтгэлд, Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолын дагуу 50.4 тэрбум төгрөг буюу 3.8 хувийг 10 ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Хүснэгт 16. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилтийн дүн /сая төгрөг/

Д/д	ТЕЗ	ТАХ-ний тоо	2020 онд санхүүжих дүн	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан дүн
1	ЗГХЭГД	1	2,038.2	480.2
2	CaC	5	82,444.5	11,087.7
3	ЭМС	12	47,226.6	7,678.2
4	УЕП	1	1,918.8	904.8
5	БОАЖС	1	947.0	164.7
6	ХЗДХС	1	678.0	91.1
7	БХБС	14	11,158.9	2,350.2
8	БШУС	13	24,853.1	4,483.9
9	ХНХС	1	2,000.0	1,105.0
10	СоС	4	52,015.7	22,087.0
	Дүн	53	225,280.8	50,432.8

Эх сурвалж: Сангийн яам

2.26. Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолоор Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан банкны баталгааг үндэслэн олгох, зарим зайлшгүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулахаар ТЕЗ нарт даалгажээ.

2.27. Дээрх тогтоолоор төсөл, арга хэмжээний үе шатны ажлын санхүүжилтийг ТЕЗ нарын барьцаа хөрөнгийн дансанд он дамжуулан байршуулахыг ТЕЗ нарт даалгаж байгаа нь данс, бүртгэлийн тогтолцоо алдагдах эрсдэлийг үүсгэж байна.

Төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээг баталснаас санхүүжилтийг он дамжуулан хэрэгжүүлэх шаардлага үүссэн байна

2.28. Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолоор Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан банкны баталгааг үндэслэн олгох, зарим зайлшгүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулахыг ТЕЗ нарт даалгасан байна.

2.29. Банкны баталгааг үндэслэн олгосон санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2020 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлж, тус яамны зөвшөөрлөөр чөлөөлөх зохицуулалттай байна.

2.30. Дээрх тогтоолын хүрээнд 2,995.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,451.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүн батлагдсан 10 ТЕЗ-ийн төсвийн багцын задарсан дүнгээр 313 ТАХ-ний 162.7 тэрбум төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан, 707.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 559.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 141 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч байгууллагад 59.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкны баталгаанд үндэслэн олгосон байна.

2.31. Аудитаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад 9 ТЕЗ-ийн 153 төсөл, арга хэмжээний 48.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гараагүй 2021 оны эхний хагас жилийн байдлаар ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд он дамжин байршиж, 33 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид банкны баталгаагаар олгосон 12.5 тэрбум төгрөг чөлөөлөгдөөгүй байгаа нь тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

2.32. Энэ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс шалтгаалсан бөгөөд цаашид төсвийн сахилга бат алдагдах, төсвийн хөрөнгө оруулалт үр ашиггүй болох үр дагавартай байна.

Төсөвлөлтийн шаардлага бүрэн хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд батлуулснаас хөрөнгийн зохицуулалт хийх шаардлага үүссэн байна

2.33. Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.14, 42 дугаар зүйлийн 42.2, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 168, 187, 253 дугаар тогтоолоор Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан ТЕЗ-ийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэхийг ТЕЗ нарт даалгасны дагуу 5 ТЕЗ төсвийн багцдаа батлагдсан 64 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 38.8 тэрбум төгрөгийн хөрөнгийн зохицуулалт хийсэн байна.

Хүснэгт 17. ТЕЗ-дын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зохицуулалт хийсэн хөрөнгийн зардлын дүн /сая төгрөг/

Д/д	ТЕЗ	Санхүүжих дүн хасагдсан ТАХ-ний			Санхүүжих дүн нэмэгдсэн ТАХ-ний		
		Тоо	Хуулиар батлагдсан санхүүжих дүн	Зохицуулалтаар хасагдсан дүн	Тоо	Хуулиар батлагдсан санхүүжих дүн	Зохицуулалтаар нэмэгдсэн дүн
1	БХС	1	991.1	991.1	1	1,000.0	991.1
2	СаС	1	15,948.7	10,000.0	1	9,953.0	10,000.0
3	БХБС	8	42,747.6	13,544.9	16	25,288.8	13,544.9
4	БШУС	16	18,869.1	12,069.5	15	15,606.0	12,069.5
5	СоС	2	12,818.0	2,200.0	3	1,200.0	2,200.0
	Дүн	28	91,374.5	38,805.5	36	53,047.8	38,805.5

Эх сурвалж: Сангийн яам

2.34. Дээрх ТЕЗ нар хөрөнгийн зохицуулалтыг хийхдээ 28 төсөл, арга хэмжээний 91.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээс 38.8 тэрбум төгрөгийг 36 төсөл, арга

хэмжээний санхүүжилтэд шилжүүлснээр 2020 онд 17 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжих боломж бүрджээ.

2.35. Харин газрын асуудал бүрэн шийдэгдээгүй, худалдан авах ажиллагаа оройтсон, зураг төсөвгүй батлагдсан ажлуудын зураг төсвийг боловсруулж магадлалаар баталгаажуулахад хугацаа алдсан, төсвийн жилд багтаан гэрээ байгуулах боломжгүй болсон зэрэг шалтгаанаар 28 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг бууруулан хөрөнгийн зохицуулалт хийсэн байна.

Барилга угсралтын үе шатны ажилд зохиогчийн техникийн хяналт хийх гэрээг ТЕЗ байгуулаагүйгээс эрх зүйн зохицуулалт зөрчигдөж байна

2.36. БШУС, ЭМС, БХБС-ын төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд зохиогчийн хяналт хийх гэрээг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ байгуулж, ажлын үр дүнг дүгнэж, санхүүжилтийг олгож байна.

2.37. Энэ нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1-д “Захиалагч нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргээс гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ”, 3.1.4-т “Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээг байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техник хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах”, БХБС-ын 2015 оны 185 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 2.1-д “Зураг төсөл зохиогч барилгын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина” гэж заасныг тус тус зөрчиж байна.

2.38. Цаашид захиалагч барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээг зураг төсөл зохиогч компанитай байгуулж, зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэн гэрээний хэрэгжилтийг хангуулж, барилга угсралтын ажлын үе шат бүрд дүгнэлт гаргуулж, үр дүнг тооцон зохих санхүүжилтийг олгож байх шаардлагатай байна.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 11.2 хувь буюу 151 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 15.2 хувь буюу 205 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дутуу байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна

2.39. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар 23 ТЕЗ-ийн төсвийн багцад 4,118.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,330.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1347 төсөл, арга хэмжээнээс 2,132.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 886.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 991 нь бүрэн хэрэгжсэн, 1,181.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 379.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 205 нь хэрэгжилт дутуу, 804.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 65.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 151 нь хэрэгжээгүй байна.

2.40. Хэрэгжилт дутуу төсөл, арга хэмжээний 72.2 хувь буюу 148 нь гүйцэтгэгч төлөвлөсөн хугацаанд ажлаа гүйцэтгээгүй, ажлын гүйцэтгэлээ хугацаанд нь гаргаж баталгаажуулаагүй, цар тахлын улмаас зарим нэр төрлийн материал хомсдож ажил удааширснаас, 27.8 хувь буюу 57 нь захиалагчийн тухайлбал, 12.5 хувь буюу 25 нь газар чөлөөлөлт хийх, зураг төсөвт өөрчлөлт орж, дахин магадлал хийлгэж хугацаа алдсан, худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулаагүйгээс, 9.3 хувь буюу 19 нь цар тахлын улмаас барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаагүй, 6.3хувь буюу 13 нь цар тахлын улмаас төсвийн орлого бүрдээгүй, санхүүжилт хугацаандаа олгогдоогүйгээс шалтгаалсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас харна уу)

2.41. Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний 49.0 хувь буюу 74 нь ТЕЗ-аас эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хугацаа алдсан, тендер шалгаруулалт амжилтгүй болсноос, 25.8 хувь буюу 39 нь гүйцэтгэгч ажлаа хугацаанд гүйцэтгээгүй, шүүхийн маргаан гарсан, барилга угсралтын явцад технологийн алдаа гаргаснаас, 10.6 хувь буюу 16 нь газрын асуудал шийдэгдээгүйгээс, 8.6 хувь буюу 13 нь батлагдсан зураг төсөлгүйгээс, 6.0 хувь буюу 9 нь бусад асуудлаас тус тус шалтгаалсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс харна уу)

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээр 353.7 тэрбум төгрөгийн 385 зөрчил илэрсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна

2.42. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасны дагуу ТЕЗ нар төсвийн төвлөрүүлэн болон харьяалах төсвийн шууд захирагч нарт тайлант онд 1,397.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 528.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 858 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах эрхийг шилжүүлжээ.

2.43. Нийт эрх шилжсэн төсөл, арга хэмжээнээс 974.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 366.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 277 төсөл, арга хэмжээ нь үргэлжлэх, 422.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 162.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 581 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжихээр батлагдсан байна.

2.44. Орон нутагт эрх шилжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагууд аудит хийж, нийт 134.9 тэрбум төгрөгийн 298 зөрчлийг илрүүлж, 22 зөрчилд 191.6 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 108 зөрчлийг арилгуулахаар 82.6 тэрбум төгрөгийн албан шаардлага өгч, 50.7 тэрбум төгрөгийн 157 зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгч, 1.4 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 2 саналыг дээд шатны удирдлагад хүргүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 18-д харуулав)

Хүснэгт 18. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын илрүүлсэн зөрчил /сая төгрөг/

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Нийт зөрчлийн дүн		Үүнээс,							
				Зөвлөмж өгсөн		Төлбөрийн акт тогтоосон		Албан шаардлага өгсөн		Хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Архангай	14	19,521.8	6	14,494.3	-	-	7	5,027.5	-	-
2	Баян-Өлгий	6	18,419.9	2	-	-	-	4	18,419.9	-	-
3	Баянхонгор	15	806.1	7	395.5	4	27.8	4	382.8	-	-
4	Булган	6	536.6	4	106.2	-	-	2	430.4	-	-
5	Говь-Алтай	16	19,436.2	8	18,079.6	-	-	8	1,356.6	-	-
6	Говьсүмбэр	8	235.4	4	-	2	1.6	2	233.8	-	-
7	Дархан-Уул	22	1,460.0	9	-	5	5.8	8	1,454.2	-	-
8	Дорноговь	11	6,934.0	8	-	-	-	3	6,934.0	-	-
9	Дорнод	10	7,923.8	3	4,287.0	-	-	4	3,636.8	1	-
10	Дундговь	14	412.3	7	-	-	-	7	412.3	-	-
11	Завхан	16	6,980.3	13	6,750.9	-	-	3	229.4	-	-
12	Орхон	7	6,149.7	5	-	-	-	2	6,149.7	-	-
13	Өвөрхангай	14	2,718.7	7	-	2	47.4	5	2,671.3	-	-
14	Өмнөговь	7	1,177.1	-	-	-	-	1	1,177.1	-	-
15	Сүхбаатар	10	61.4	9	-	1	61.4	-	-	-	-
16	Сэлэнгэ	9	2,265.2	-	-	-	-	9	2,265.2	-	-
17	Төв	24	5,841.9	9	-	3	39.6	12	5,802.3	-	-
18	Увс	9	82.2	5	-	-	-	4	82.2	-	-
19	Ховд	6	19,801.5	1	846.4	2	3.6	2	17,582.7	1	1,368.8
20	Хөвсгөл	23	4,580.8	16	3,135.7	3	4.4	4	1,440.7	-	-
21	Хэнтий	27	38.2	17	-	-	-	10	38.2	-	-
22	Нийслэл	24	9,495.4	17	2,595.4	-	-	7	6,900.0	-	-
Дүн		298	134,878.5	157	50,691.0	22	191.6	108	82,627.1	2	1,368.8

Эх сурвалж: Орон нутаг дахь Төрийн аудитын газар

2.45. ТЕЗ-ийн төсвийн багцад орон нутагт эрх шилжүүлээгүй хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд нийт 218.8 тэрбум төгрөгийн 87 зөрчил илрүүлж, 10

зөрчилд 2.9 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 23 зөрчлийг арилгуулахаар 194.2 тэрбум төгрөгийн албан шаардлага өгч, 21.7 тэрбум төгрөгийн 51 зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгсөн байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 19-т харуулае)

Хүснэгт 19. ТЕЗ-даас орон нутагт эрх шилжүүлээгүй ТАХ-ний хэрэгжилтэд илрүүлсэн зөрчил /сая төгрөг/

Д/д	ТЕЗ-дын нэр	Нийт зөрчлийн дүн		Үүнээс,		Төлбөрийн акт тогтоосон		Албан шаардлага өгсөн	
				Зөвлөмж өгсөн					
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	CaC	2	22,777.0	-	-	-	-	2	22,777.0
2	ХНХС	6	4.4	4	-	2	4.4	-	-
3	БХБС	4	527.8	2	-	2	527.8	-	-
4	БШУС	15	60,584.1	8	-	2	296.2	2	60,287.9
5	ЭХС	5	-	5	-	-	-	-	-
6	СоС	12	23,757.9	9	21,700.0	3	2,057.9	-	-
7	ЗТХС	11	1,906.4	10	-	-	-	1	1,906.4
8	ЭМС	24	98,518.2	9	-	-	-	15	98,518.2
9	ХХААХҮС	3	10,750.0	-	-	-	-	3	10,750.0
10	ҮХЦ	4	-	4	-	-	-	-	-
11	БОАЖС	1	5.8	-	-	1	5.8	-	-
Дүн		87	218,831.6	51	21,700.0	10	2,892.1	23	194,239.5

Эх сурвалж: УАГ

2.46. Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 353.7 тэрбум төгрөгийн 385 зөрчлийг илрүүлж, 32 зөрчилд хамаарах 3.1 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 131 зөрчлийг арилгуулахаар 276.9 тэрбум төгрөгийн албан шаардлагыг өгч, 72.4 тэрбум төгрөгийн 208 зөрчлийг арилгуулах зөвлөмж, 1.3 тэрбум төгрөгийн 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар тус тус хүргүүлэв.

Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хууль, эрх зүйн зохицуулалт зөрчигдсөөр байна

2.47. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байнгын ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээг төрийн болон орон нутгийн өмчид бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1-т “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршилээр данс бүртгэлд тусгана” гэж заасныг тус тус зөрчсөн байна. Тухайлбал,

Архангай аймагт:

- Сургалт, олон нийтийн мэдээллийн төвийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/ ТАХ-ний 495.0 сая, 500 оюутны байр /Улаанбаатар хот/ ТАХ-ний 6,000.0 сая, Хархорин-Цэцэрлэг чиглэлийн авто замаас сумын төв хүртэлх хатуу хучилттай авто зам, 8.5 км /Архангай, Төвшрүүлэх сум/ ТАХ-ний 6,710.1 сая, Сумын төвийн авто замын засвар, 4 км /Архангай, Хангай сум/ ТАХ-ний 469.3 сая, Хоргын тогоо чиглэлийн авто замын засвар, 6 км /Архангай, Тариат сум / ТАХ-ний 598.9 сая, Малын угаалгын цэг байгуулах /Архангай, Өлзийт/ ТАХ-ний 42.0 сая, Сум дундын малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын лабораторийн барилгын 179.0 сая нийт 14,494.3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.

Дундговь аймагт:

- Засаг даргын Тамгын газрын барилга /Дундговь, Гурвансайхан сум/, Цэцэрлэгийн барилга, 200 ор /Дундговь, Өндөршил сум/, Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум/ төсөл, арга хэмжээний 3,691.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй.

Орхон аймагт:

- Найман төсөл, арга хэмжээг 4,900.2 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн.

Баян-Өлгий аймагт:

- Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт, Дэлүүн сумын Сум дундын эмнэлгийн барилгын барилгын их засвар, Өлгий сумын ЗДТГ-ын компьютер, техник хэрэгсэл, Буянт сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар, аймгийн төвийн авто замын өргөтгөл, шинэчлэлт 10.4 км, авто зам, зогсоолын шинэчлэл, Сагсай сумын Даян багийн 50 ортой цэцэрлэгийн барилга, Толбо сумын ЦДАШ 0.4 кВт гэсэн 8 ТАХ-ний нийт 17,052.7 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.

Увс аймагт:

- Дотуур байрны барилгын өргөтгөл /Увс, Тэс сум/ ТАХ-ний 1,774.1 сая, Цэцэрлэгийн барилга /Увс, Тариалан сум/ ТАХ-ний 2,200.0 сая, Соёлын төвийн барилга /Увс, Давст сум/ ТАХ-ний 1,500.0 сая, Соёлын төвийн барилга /Увс, Түргэн сум/ ТАХ-ний 1,740.0 сая, Соёлын төвийн барилга /Увс, Цагаанхайрхан сум/ ТАХ-ний 2,000.0 сая, ЗДТГ-ын барилга /Увс, Сагил сум/ ТАХ-ний 1,300.0 сая, Цэцэрлэгийн барилга /Увс, Зүүнговь сум/ ТАХ-ний 1,200.0 сая, Спорт заалны барилга /Увс, Зүүнговь сум/ ТАХ-ний 800.0 сая, нийт 12,514.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй.

Завхан аймагт:

- Хөрөнгө, сурах бичгийн 553.7 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй, 30.68 сая төгрөгийн хөрөнгө нийлүүлэгдээгүй байхад бүртгэлд тусгасан;

Баянхонгор аймагт:

- Нийт 25,572.9 сая төгрөгийн 16 ТАХ-г данс бүртгэлд тусгаагүй.

Өвөрхангай аймагт:

- Төрийн захиргааны байгууллагуудын тоног төхөөрөмж /Өвөрхангай, Бат-өлзий, Хархорин, Зүүнбаян-Улаан, Хужирт, Уянга сум/ 200.0 сая төгрөгийн багцаас “Сүүн хүнгий” ХХК-ийн нийлүүлсэн 50.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг сумдад хуваарилаагүй, аймгийн ЗДТГ-ын агуулахад хадгалагдаж байна. Орон нутгийн өмчийн газар ямар нэгэн шийдвэр гаргаж бүртгэлд тусгаагүй байна.
- Боловсрол, соёл, спортын салбарын их засвар, тоног төхөөрөмж /Өвөрхангай, Хархорин, Хужирт, Зүүнбаян-Улаан, Бат-өлзий, Уянга сум/ 1,500.0 сая төгрөгийн багцаас “Ий би си” ХХК-ийн нийлүүлсэн 205.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг дээрх сумууд бүртгэлд тусгаагүй байна.
- Боловсрол, соёлын салбарын байгууллагуудын тоног төхөөрөмж /Өвөрхангай/ 500.0 сая төгрөгийн багцаас “Сүү хүнгий” ХХК-ийн нийлүүлсэн 23.7 сая төгрөгийн зөөлөн эдлэл, “Түшиг вилла” ХХК-ийн нийлүүлсэн 245.8 сая төгрөгийн 7 кабинет, тоног төхөөрөмж, “Сүү хүнгий” ХХК-ийн нийлүүлсэн 61.5 сая төгрөгийн 3 ширхэг “Grand Starix” автомашин зэргийг бүртгэлд тусгаагүй байна.

Дархан-Уул аймагт:

- Орхон сумын 395.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төвийн ундны цэвэр усны хангамжийн эх үүсвэр”, Дархан сумын 163.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн орон сууцын засвар, шинэчлэл фасадны гэрэлтүүлэг”, Дархан сумын 86.6 сая төгрөгийн төсөв өртөгтэй “Нийтийн орон сууцын засвар, шинэчлэл багц-3 дээвэр, их засвар багц-2”, Дархан сумын 776.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн орон сууцын засвар, шинэчлэл ФАСАД” ТАХ-г данс бүртгэлд тусгаагүй байна.

Говьсүмбэр аймагт:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн боловч хүлээн аваагүй, бүртгэлд тусгаадаагүй 233.8 сая төгрөгийн хөрөнгө байна.

Говь-Алтай аймагт:

- Цагдаагийн газрын барилгын 2,075.0 сая, Солонго хорооллын орон сууцын хорооллын гадна инженерийн шугам сүлжээ 5,814.3 сая, Аймгийн төвүүдийн үерийн хамгаалалт 1,334.4 сая, Анагаах ухааны үндэсний их сургуулийн харьяа Говь-Алтай аймаг дахь салбар сургуулийн 5,888.2 сая, Өрхийн эмнэлгийн автомашины 60.0 сая, Багийн эмчийн 39 мотоциклын үнэ 70.0 сая, нийт 15,241.9 сая төгрөгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Хөвсгөл аймагт:

- Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Ханх сум/ ТАХ-ний 1,200.0 сая, Ахмадын өргөөний барилга худалдан авах /Хөвсгөл, Төмөрбулаг сум/ ТАХ-ний 200.0 сая төгрөг байна.

2.48. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд нийт 156 аж ахуйн нэгжид 2-13 ажлыг давхардуулж гэрээ байгуулсан нь төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх эрсдэл үүссэн байна. Тухайлбал,

- “Бум констракшн” ХХК-д Дундговь аймгийн “Сайнцагаан сумын Ахмадын өргөөний барилга”, “Говь-Угтаал сумын Спорт заалны барилга”-ын ажлыг давхардуулж өгснөөс “Говь-Угтаал сумын Спорт заалны барилга”-ын угсралтын ажил хийгдээгүй;
- “Одда тайж” ХХК-д Дундговь аймгийн “Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар”, “Өлзийт сумын Цэцэрлэгийн барилгын их засвар”, “Дэлгэрцогт сумын Соёлын төвийн барилга”-ын ажлыг давхардуулж өгснөөс хэрэгжээгүй;
- “Гурван тамир” ХХК-тай Архангай аймагт хэрэгжсэн нийт 8 ажилд гэрээ байгуулснаас “Нэгдсэн эмнэлгийн барилга, 300 ор /Архангай, Эрдэнэбулган сум/” төсөл, арга хэмжээнд 2020 онд батлагдсан 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг ашиглаагүй, ажлын гүйцэтгэл дутуу;
- “Арвин бэлт” ХХК-тай Хэнтий аймагт хэрэгжиж буй 4 ажилд гэрээ байгуулан ажилласнаас “Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Харуул-Алтай хотхон/” төсөл, арга хэмжээний 2020 оны гүйцэтгэл дутуу, 598.8 сая төгрөгийн санхүүжилтийг ашиглаагүй;
- “Акми холдинг” ХХК 32.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүн бүх 2 ажлын гүйцэтгэгчээр ажиллаж, гэрээгээр 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ашиглалтад оруулах хугацаатай “Үндэсний номын сангийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/” барилгын ажлын гүйцэтгэл 94.0 хувьтай, 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ашиглалтад оруулах “Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/” барилгын ажлын гүйцэтгэл 75.0 хувьтай байна.
- “Арц суварга” ХХК 13.8 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 2 ажлын гүйцэтгэгчээр ажиллаж, гэрээгээр ашиглалтад оруулах хугацаа дууссан боловч ажлын гүйцэтгэл 66.2-91.0 хувьтай;
- “Билгүүн Монгол констракшн” ХХК 68.9 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 3 ажлын гүйцэтгэгчээр ажилласнаас “Чингис хаан музейн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/” барилгыг гэрээний дагуу 2020 оны 12 дугаар сарын 25-ны дотор ашиглалтад оруулах хугацаатай боловч ажлын гүйцэтгэл 98.4 хувьтай;
- “Зуурмаг” ХХК 2.9 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 2 ажлын гүйцэтгэгчээр ажилласнаас “Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Идэр сум/” барилгыг 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн дотор ашиглалтад оруулах үүрэг хүлээсэн боловч ажлын гүйцэтгэл 23.4 хувьтай;
- “Мотор сервис” ХХК 10.1 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий 3 ажлын гүйцэтгэгчээр ажилласнаас 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр ашиглалтад оруулах үүрэг хүлээсэн “Орхон голын Онгоцтойн амны төмөр бетон гүүр, 220 у/м /Өвөрхангай, Бат-Өлзий сум/” төслийн хэрэгжилт 88.1 хувьтай;
- “Заабар” ХХК 3.7 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий 3 ажлын гүйцэтгэгчээр ажилласан, үүнээс 2020 онд ашиглалтад оруулах 2 ажлын гүйцэтгэл 50.6-99.6 хувийн гүйцэтгэлтэй;
- “Уран охид” ХХК 3.0 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий 2 ажлын гүйцэтгэгчээр ажилласан, хугацаандаа ашиглалтад ороогүй, ажлын гүйцэтгэл 46.0-57.0 хувьтай;
- “Жоншт” ХХК 3.0 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий 2 ажлын гүйцэтгэгчээр ажилласнаас 2020 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор ашиглалтад оруулах үүрэг бүхий “Солийн Данзангийн нэрэмжит музей, цэцэрлэгт хүрээлэн /Архангай, Хотонт сум/” төслийн хэрэгжилт 67.0 хувьтай;
- “Хасу мегаватт” ХХК 18.0 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий 2 ажлын гүйцэтгэгчээр ажилласнаас 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ашиглалтад оруулах “У-18 цэгээс 7и магистраль ДХ-7138 дугаар цэг хүртэл шинээр 2Ф700мм голчтой дулааны шугамын барилга угсралтын ажил” төсөл хэрэгжилт дутуу;

- “Сүхжин” ХХК 3.2 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 2 ажлын гүйцэтгэгчээр ажилласнаас 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ашиглалтад оруулах “Музейн барилга /Дорнод, Хэрлэн сум/” төслийн хэрэгжилт 47.0 хувьтай;
- Цэгц мандал” ХХК 2.4 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 2 ажлын гүйцэтгэгчээр ажилласнаас 2020 онд дуусгах хугацаатай төслийн хэрэгжилт 4.2-95.0 хувьтай;
- “Бумбат даваа” ХХК 1.3 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 2 ажлын гүйцэтгэгчээр ажилласнаас 2020 онд дуусгах хугацаатай төслийн хэрэгжилт 55.5-98.3 хувьтай;
- “Тэргүүн саруул зам” ХХК 7.4 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 2 ажлын гүйцэтгэгчээр ажилласнаас 2020 онд дуусгах хугацаатай төслийн хэрэгжилт 69.9-99.8 хувьтай;
- “Ди Вай Кэй Би” ХХК нийт 10.6 тэрбум төгрөгийн 2020 онд багтаан дуусгах хугацаатай 3 ажлын гүйцэтгэгчээр ажилласнаас 2 ажлын гүйцэтгэл 33.5-95.2 хувийн хувьтай дутуу;
- “Саруул цамхаг” ХХК 6.7 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 2020 онд дуусгах хугацаатай 2 төслийн гүйцэтгэгчээр ажилласнаас “Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/” төслийн хэрэгжилт 76.6 хувьтай дутуу;
- Тэмүүн холдинг ХХК 13.7 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 5 төслийн гүйцэтгэгчээр ажилласнаас 2020 онд дуусгах хугацаатай 3 төслөөс 2 төслийн хэрэгжилт дутуу 87.2-93.0 хувьтай;
- Монкон констракшн ХХК 4.2 тэрбум төгрөгийн 2020 онд дуусгах хугацаатай 2 төслийн гүйцэтгэгчээр ажиллаж байгаагаас хэрэгжилт дутуу 28.0-99.0 хувийн гүйцэтгэлтэй;
- Грийн ресурс ХХК 2020 онд дуусгах хугацаатай 8.2 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 2 төслийн гүйцэтгэгчээр ажиллаж байгаагаас хэрэгжилт 42.5-42.9 хувьтай дутуу байна.

2.49. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд байнгын ашиглалтад оруулах комиссын болон захиалагчийн техник хяналтаар өгсөн үүргийн биелэлт хангалтгүй байна. Тухайлбал,

Дундговь аймагт:

- Хатуу хучилттай авто зам, 2.8 км /Эрдэнэдалай сум/ ТАХ-ний гүйцэтгэгч “Анарзоне” ХХК зарим ажлыг зураг төслийн дагуу хийгээгүй, бетоны гадаргууд хагарал их үүссэн, авто зогсоолын суурийн нягтруулалт хийхгүйгээр сул хөрс асгаж бетон цутгалт хийсэн, зорчих хэсгийн ус зайлуулах байгууламжийг хийгээгүй, хучилтын заадас гаргалгүй цутгасан зөрчил дутагдлыг арилгуулахаар ГХБХБГ-аас үүрэг даалгавар өгсөн боловч биелүүлээгүй байна.

Баянхонгор аймагт:

- Дотуур байрын барилга /Баянхонгор, Жинст сум/ ТАХ-ний гүйцэтгэгч “Жамъян пайтан” ХХК-ийн 2019 оны үлдэгдэл санхүүжилт 113.6 сая төгрөгийг Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн сангийн барьцаа хөрөнгийн 51350 тоот харилцах дансанд байршуулсан ба гүйцэтгэгч компанийн гаргасан гүйцэтгэлийг Барилга хөгжлийн төвөөс магадалшгүй ажлын зардал 24.0 сая төгрөгийг хасаж 89.6 сая төгрөг олгохоор хянасан байхад 24.0 сая төгрөгийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Ховд аймагт:

- Байнгын ашиглалтад хүлээн авах комиссоос 350.0 сая төгрөгийн өртөгтэй Буянт сумын төвийн төмөр бетон гүүр ТАХ-ний гүйцэтгэгч “Тоёо” ХХК-нд төмөр бетон гүүрний ажилд хаяавч хийлгэх, хамгаалалтын хашлага хийлгэх шаардлагыг өгсөн боловч хэрэгжээгүй;
- “БЭСА” ХХК-ийн гүйцэтгэсэн 100.0 сая төгрөгийн өртөгтэй Мянгад сумын Усны голдирол өөрчлөх, суваг шуудуу сэргээх, шинээр татах ажлын усны боолтыг сайжруулахаар өгөгдсөн үүргийг хэрэгжүүлээгүйгээс боолт сэтэрсэн;
- “Монголиа блюдинг консалтинг” ХХК-ийн гүйцэтгэсэн 137.0 сая төгрөгийн өртөгтэй Мөст сумын Халуун усны барилгын агааржуулалтыг сайжруулах, сауны тоног төхөөрөмж, цэвэр усны тэжээлийн шугам, бохир зайлуулах шугам зэргийг зургийн дагуу хийх үүрэг өгөгдсөн боловч хэрэгжээгүй;

- “Саруул цамхаг” ХХК-ийн гүйцэтгэсэн Спорт, соёлын төвийн заалны барилга, 300 суудал /Ховд, Мөнххайрхан сум/ ТАХ-ний тайзны гэрэлтүүлэг дутуу, хяналтын камер суурилуулах, усны хаялга хийх, сагсны шийд байрлуулах, онооны электрон самбар байрлуулах, гадна тохижилт хийх зэрэг шаардлагууд хэрэгжээгүй;
- “Хос Арыс” ХХК-ийн гүйцэтгэсэн 183.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Ховд, Ховд сум/ ТАХ-ний 30 хаалга шинэчлэх, шал будах, дээврийн усны хамгаалалт, гар угаалтуур бүрэн хийх зэрэг ажлууд хийгдээгүй.

Булган аймагт:

- Могод сумын сургуулийн гал тогооны их засварын ажил, Бугат сумын сургуулийн дотуур байрны барилгын ажлуудад байнгын ашиглалтад оруулах комиссоос үүрэг даалгавар өгсөн ч ажлууд хийгдээгүй.

Дорнод аймагт:

- Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний төв хаалганы хэсгийн халаалтын радиаторыг хэвтээ чиглэлд бэхлэх, зоорины давхрын гадна цонхны саравчийг уртасгах, дээврийн төмөр дарлагын уулзварыг чимхэж битүүмжлэх ажил хийгдээгүй;
- Дотуур байрны барилга /Дорнод, Баяндун сум/ ТАХ-ний гадна талбайн тохижилтын ажлыг хийх, халаалтын тогоонд баталгаа гаргаж өгөх ажил хийгдээгүй;
- Соёлын төвийн барилгын их засвар /Дорнод, Цагаан-Овоо сум/ ТАХ-ний дээврийн хөндий рүү гарах гарцыг хийх, зуух будах, босоо шугам бэхлэх, цахилгаан самбарын схем байршуулах ажил хийгдээгүй;
- Дотуур байрны барилгын их засвар /Дорнод, Булган сум/ ТАХ-ний хойд талын хананы фасадыг хүзүүвчээр холболт хийгдсэний дараа хийж дуусгах ажил хийгдээгүй.
- Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Дорнод, Чулуунхороот сум/ ТАХ-ний Хаалганы хүрээ модыг бэхлэх, гэрлүүдийг солих ажил хийгдээгүй байна.

2.50. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний магадлашгүй ажлын зардал, захиалагчийн техник хяналтын зардлыг холбогдох дансанд шилжүүлээгүй, зориулалт бусаар зарцуулсан зөрчил жил бүр давтагдан гарсаар байна. Тухайлбал,

Архангай аймагт:

- Техник хяналтын зардлын данснаас 2020 онд 126.5 сая төгрөгийг аймгийн Засаг даргын захирамжийн дагуу ГХБХБГ-ын дансанд автомашин худалдан авахад шилжүүлсэн.

Орхон аймагт:

- Орон нутгийн барьцаа хөрөнгийн дансанд санхүүжилтийг байршуулсан 6 ТАХ-ний 46.7 сая төгрөгийн техник хяналтын зардлыг холбогдох дансанд шилжүүлээгүй;
- Нэг ТАХ-ний 3.5 сая төгрөгийн техник хяналтын зардлыг суутгахгүйгээр гүйцэтгэгч компанид олгосон.

Өвөрхангай аймагт:

- Тайлант онд ТЕЗ-даас Засаг даргад эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын төсвөөс барилга угсралт, их засварын техник хяналтын зардалд 235.2 сая төгрөгийг суутгаж Төрийн сан дахь “Техник хяналт, барьцаа” дансанд оруулсан боловч уг хяналтыг хэрэгжүүлж буй ГХБХБГ-т 13.9 сая төгрөг олгож, аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 56.4 сая төгрөг, худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийн урамшуулалд 5.4 сая төгрөг зарцуулсан байна.

Дархан-Уул аймагт:

- Дархан сумын 12 дугаар сургуулийн дотуур байрны их засварын ажлыг гүйцэтгэсэн “Өсөх буянт тулга” ХХК-нд магадалшгүй ажлын зардлаас материалын зардалд 0.6 сая төгрөгийг илүү тооцож олгосон;
- Нийтийн орон сууцын фасад гэрэлтүүлгийн ажлыг хийж гүйцэтгэсэн “Лед сити” ХХК-д магадалшгүй ажлын зардлыг тооцож олгохдоо материалын зардалд 0.3 сая төгрөг илүү тооцож олгосон;
- Дархан сумын 18 дугаар сургуулийн спорт талбайн их засварын ажлыг гүйцэтгэсэн “Дархан трейд” ХХК их засварын ажлын төсөвт тусгагдсан 3.0 сая төгрөгийн өртөгтэй хөл бөмбөгийн 2 хаалга хийгдээгүй, хуучин хаалгыг нь будаж тавьсан, ажлын зураг төсөвт тусгагдсан ажил захиалагч талаас тавьсан хүсэлтийн дагуу өөрчлөлт оруулсан байна. Ингэхдээ материалын тооцоог зөрүүтэй тооцож 0.6 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.

Говь-Алтай аймагт:

- ЗГХЭГ-ийн даргын багцаас Эрдэнэ сумын ЗДТГ-ын барилгын ТАХ-нд шилжүүлсэн санхүүжилтээс 23.9 сая төгрөгийг техник хяналтын зардлын дансанд төвлөрүүлэн нийт дүнгээр ГХБХБГ-т шилжүүлсэн боловч Барилгын хөгжлийн төвд 7.9 сая төгрөгийг зохиогчийн хяналтын зардалд 2020 оны 11 сард давхардуулан шилжүүлсэн;
- Техник хяналтын дансанд орлого оруулаагүй байтал 5, 6, 7, 13, БУК-18, Эрчмийн 8 айлын орон сууцуудын гадна засвар магадлашгүй ажилд 1.2 сая төгрөгийг 2019 оны 12 сард “Харшийн цуурай” ХХК-д шилжүүлсэн байна.

Соёлын яам:

- Улсын комисс хүлээн авч байнгын ашиглалтад орсон 10 төсөл, арга хэмжээний техник хяналтын зардлын зарцуулаагүй үлдэгдэл 15.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, зориулалт бусаар 8.8 сая төгрөг зарцуулсан байна.

2.51. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ төсөл, арга хэмжээний бодит бус гүйцэтгэлийг баталгаажуулж гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг олгуулах нөхцөлийг бүрдүүлж байгаа зөрчил жил бүр давтагдан гарсаар байна. Тухайлбал,

- Нийслэл, аймгийн төвүүдийн үерийн хамгаалалтын шинэчлэлт, зураг төсвийн хамт /Улсын хэмжээнд/ - Баянхонгор 2, 7-р баг төсөл, арга хэмжээний 221.3 сая төгрөгийн гүйцэтгэл гараагүй байхад баталгаажуулсан.

2.52. Төсвийн тухай хуульд төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тойм болон ажлын тоо хэмжээ дутуу дүнгээр батлуулснаас дутуу хэрэгжих, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болж байна. Тухайлбал,

Баян-Өлгий аймагт:

- Тыва бага сургуулийн барилга, 360 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум/ ТАХ-ний төсөвт өртгийг төсвийн тухай хуульд 1,200.0 сая төгрөгөөр баталсан боловч магадлалаар баталгаажсан төсөвт өртөг 2,382.7 сая төгрөг байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “Ганбарс” ХХК 2020 онд 1 давхрын бетон цутгалтын ажлыг хийж, барилга угсралтын ажил зогссон;
- Дотуур байрны барилга, 150 ор /Баян-Өлгий, Цэнгэл сум/ ТАХ-ний барилга угсралтын ажил 2020 онд дууссан боловч гадна инженерийн шугам сүлжээний ажлууд барилгын зураг төсөлд тусгаадаагүйгээс гүйцэтгэгч “Алтайн газрын хүч” ХХК байнгын ашиглалтад хүлээлгэж өгөөгүй;
- Соёлын төвийн барилга, 300 суудал /Баян-Өлгий, Дэлүүн сум, Улаанхус сум, Бугат сум/, Спорт цогцолборын барилга, 105 суудал /Баян-Өлгий, Ногооннуур/ ТАХ-ний улсын төсөвт тусгагдсан төсөвт өртгөөс магадлалаар баталгаажуулсан төсөвт өртөг их гарч төсвийн зөрүү хөрөнгийн асуудлаас гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй байна.

Ховд аймагт:

- ТАХ-ний ажлын тоо хэмжээг зураг төсөлд бүрэн тусгаагүйгээс Сургуулийн барилгын засвар /Ховд, Үенч сум, Хөх үзүүр баг/ ТАХ 21.0 сая, Сургуулийн барилгын их засвар /Ховд, Мянгад сум/ ТАХ 25.2 сая, Сургуулийн барилгын их засвар /Ховд, Цэцэг сум/ 44.9 сая, Сургуулийн барилгын их засвар /Ховд, Дуут сум/ ТАХ 11.5 сая, Нийтийн эзэмшлийн орон сууцын дээврийн их засвар /Ховд, Жаргалант сум/, ЗДТГ-ын барилга /Ховд, Эрдэнэбүрэн сум/ ТАХ 76.7 сая, Сургуулийн барилга, 640 суудал /Ховд, Жаргалант сум, Цаст-Алтай цогцолбор сургууль/ ТАХ 292.8 сая, Сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудал /Ховд, Алтай сум/ ТАХ 305.9 сая нийт 846.4 сая төгрөгийн нэмэлт ажил хийгдсэн;

Нийслэлд:

- ТАХ-ний ажлын тоо хэмжээг зураг төсөлд бүрэн тусгаагүйгээс Цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих, 240 ор /УБ, ХУД, 28 дугаар цэцэрлэг/ ТАХ-ний төсөвт өртөг магадлалаар 728.1 сая, Цэцэрлэгийн барилга, 250 ор /УБ, СХД, 31 дүгээр хороо/ ТАХ-ний төсөвт өртөг магадлалаар 500.0 сая, Цэцэрлэгийн барилга, 150 ор /УБ, СХД, 10 дугаар хороо/ ТАХ-ний төсөвт өртөг магадлалаар 250.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;

Дархан-Уул аймагт:

- "Миний Монгол" цэцэрлэгт хүрээлэнгийн хөл бөмбөгийн иж бүрэн талбай, тохижилт /Дархан-Уул, Дархан сум/ ТАХ-ний төсөвт өртөг магадлалаар 92.2 сая, Төвийн ундны цэвэр усны хангамжийн эх үүсвэр /Дархан-Уул, Орхон сум/ ТАХ-ний төсөвт өртөг магадлалаар 11.3 сая, Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Дархан-Уул, Орхон сум/ ТАХ-ний төсөвт өртөг магадлалаар 85.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;

Дорнод аймагт:

- Цэцэрлэгийн шинэ барилга /Дорнод, Баянтүмэн сум/ ТАХ-ний төсөвт өртөг магадлалаар 463.0 сая, Соёлын төвийн барилга /Дорнод, Баян-Уул сум/ ТАХ-ний төсөвт өртөг магадлалаар 362.0 сая, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний төсөвт өртөг магадлалаар 234.9 сая, Улз голын урсцыг нэмэгдүүлэх "Онон-Улз" төсөл /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний төсөвт өртөг магадлалаар 1,914.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Говь-Алтай аймагт:

- Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь-Алтай, Бигэр сум/ ТАХ-ний төсөвт өртөг 100.0 сая, Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь-Алтай, Жаргалан сум/ ТАХ-ний төсөвт өртөг 100.0 сая, Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь-Алтай, Төгрөг сум/ ТАХ-ний төсөвт өртөг 100.0 сая, Сургуулийн барилга, спорт заалны барилга, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг сум, Эрүүл мэндийн шинжлэх ухааны Их сургуулийн харьяа Анагаах ухааны коллеж/ ТАХ-ний төсөвт өртөг 745.2 сая, Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Говь-Алтай, Цээл сум/ ТАХ-ний төсөвт өртөг 1,006.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

2.53. Улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг буурч байна. Тухайлбал,

Баян-Өлгий аймагт:

- ГХБХБГ-ын Барилга, хот байгуулалтын хэлтэс нь захиалагчийн хяналт хийсэн тайлан гаргаагүй, хяналт хийсэн тухай нэгдсэн бүртгэл хөтлөөгүй, мэдээллийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаагүй, захиалагчийн үүргийг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна. Мөн 2020 онд ашиглалтад оруулсан 4,487.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн төвийн 3.5 км хатуу хучилттай авто замын шинэчлэлтийн ажлын Нэгдсэн эмнэлгийн урд уулзвараас "Тирлик" захын Ногоон суурьшил гудамжны чиглэл, "Тирлик" захын чиглэлийн зарим газруудын явган хүний зам нь зураг төслийн дагуу хийгдээгүй байна.

Хэнтий аймагт:

- Хөл бөмбөгийн талбай бүхий спортын цогцолборын тохижилт /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ ТАХ-ний хиймэл зүлгийг технологийн дагуу дэвсээгүй, хашааны хаалга зургийн дагуу хийгдээгүй, үзэгчдийн сандал, гэрэлтүүлэг, машины зогсоол дутуу, сагсан бөмбөг, теннисийн талбай, гүйлтийн зам нь стандартын шаардлага хангахгүй хийгдсэн;
- ЗДТГ-ын барилга /Хэнтий, Галшар сум/ ТАХ 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжиж 2020 оны 12 сард байнгын ашиглалтад орсон боловч уг сард халаалтын 23 паар хагарснаас шалны плита ховхорсон, паркетан шал овойж ховхорсон, өрөөнүүдийн чийгшил нэмэгдсэнээс цонх хагарч, гажилт, суулт өгсөн, хананд хагарлууд гарсан зэрээр барилгын чанарт нөлөөлж тус сумын ЗДТГ шинэ барилгад өнөөг хүртэл ашиглаагүй байна.

Увс аймагт:

- Цэцэрлэгийн барилгын засвар /Увс, Өлгий сум/ ТАХ дуусаж, байнгын ашиглалтад хүлээн авсан хэдий ч хаалганы босго хэт өндөр, бариулыг стандарт бус суулгасан, зарим өрөөний тааз хөгцөрсөн, хаалга хаагдахгүй гажсан, коридорын шалны түвшин, ангиудын шалны түвшин зөрүүтэй хийгдсэн;
- Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Увс, Баруунтуруун сум/ ТАХ-ний ажил дууссан боловч морг, уурын зуухны барилгын дээврийн хар цаас салхинд хуурч унасан, барилгын гадна хананд цууралт үүссэн, зарим өрөөний цахилгаан тасардаг, халаалтын тогоог ашиглалтад оруулаагүй;
- Соёлын төвийн барилга /Увс, Цагаанхайрхан сум/ ТАХ ашиглалтад орсон хэдий ч зарим өрөөний хананд цууралт үүссэн, салхи шуурганд цонхоор шороо ордог, заал, таазны дуу намсгагч хуурч унасан;

- Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /Увс, Цагаанхайрхан сум/ ТАХ дуусаж, ашиглалтад орсон хэдий ч зарим өрөөний хананд цууралт үүсэн, салхи шуурганд цонхоор шороо ордог, өвлийн улиралд дулаан алдалт ихтэй, бохирын шугам хөлдсөн;
- Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн барилгын их засвар /Увс, Өмнөговь сум/ ТАХ-ний ажил дуусаж, ашиглалтад орсон хэдий ч гадна заслын шавар ховхорч унасан, зарим өрөөний цонхоор шороо ордог, цонхны салхивч хаагдахгүй, барилгын "Б"корпусын дээврийг будаагүй;
- Наранбулаг, Өмнөговь сумдын цаг уурын өртөөний барилгын ажил дуусаж, улсын комисс ажиллахад суурийн цутгалд стандартад хүрээгүй, мөн хүүхдийн эмнэлгийн барилгад лифт холбоо дохиолол дутуу хийсэн зөрчил тус тус илэрсэн тул улсын комисс хүлээн аваагүй байна.

Баянхонгор аймагт:

- Дотуур байрын барилга /Баянхонгор, Жинст сум/ ТАХ ашиглалтад орсноос хойш салхи шуурганаар дээврийн 10 м.кв талбайн хар цаас хуурч унасан, өрөө танхимд суулт өгч, хана блок хоорондын залгаагаар хагарсан, өрөөнүүдэд агааржуулалтын хоолой байхгүйгээс бүгчим байна;
- Бага сургуулийн барилга, 240 суудал /Баянхонгор, Баян-Овоо сум/ ТАХ 2020 онд ашиглалтад орсон боловч хананд цууралт үүссэн, ангиудын цонх хагарсан, сангийн шугам шаардлага хангаагүйгээс шалан доогуур удаа дараа ус алдсан, 1 давхрын 3 ангийн цахилгааны монтажид гал гарч цахилгааны утас шатсан, хаалга, цонхны хамгаалалт резин хийгээгүйгээс тоосжилт ихтэй байна;
- Сургуулийн барилга, 240 суудал /Баянхонгор, Жинст сум/ ТАХ-ний спорт заал, урлаг заалны дээврээс хур тунадас орсон үед ус гоождог, их хэмжээний шороо тоос ордог, салхи шуурганаар 3 давхрын гадна фасад 12 м.кв орчим хуурч унасан;
- Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Баянхонгор, Өлзийт сум/ ТАХ-ний агааржуулалтын хоолойтой холбоотой дулаан алдалт их, шороо тоос их ордог дуу чимээ ихтэй, цэврийн шугам задарч ус алдсанаас 1 давхрын таазанд нуралт үүссэн, барилгын хананд цууралт үүссэн, дотор хананы шавар нурсан, дотор ариун цэврийн өрөөг ашиглах боломжгүй бохир үнэртдэг, хуучин барилгын засварласан шал стандарт бус учир халтирдаг, дотор өрөөнүүдэд сольсон шинэ хаалганууд нь эвдэрч эхэлсэн, өрөөнүүдийн цонхыг бүрэн солиогүй;
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Баянхонгор, Баян-Өндөр сум/ ТАХ салхи шуурганаар барилгын дээврийн хүрээлсэн төмөр хуурч унасан, гадна талын үерийн далангийн хэсэг дутуу хийгдсэн, явган хүний замын хэсэг, үүдний тамбар, шатыг гөлгөр плитагаар хийсэн, ариун цэврийн өрөөний плитаг зориулалтын бус цавуугаар нааснаас нурсан, хулдаас хуурсан, дотор хөлийн хэсгийн хана цуурсан байна;
- Цэцэрлэгийн барилгын их засвар /Баянхонгор, Жинст сум/ ТАХ ашиглалтад орсноос хойш сар хүрэхгүй хугацаанд цонх, хаалганы түгжээ, шалны залгаас эвдэрч амлагааны шавар хагарсан, дулаан алдалт ихтэй, цонхны төмөр хаяавч ховхорсон, гал тогооны агааржуулагч ажиллахгүй байна;
- Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баянхонгор, Баян-Өндөр сум/ ТАХ-ний өрөөнүүдийн тааз муу, эмийн сангийн зориулалтын өрөөний тааз нурж унасан, халаалтын шугам буруу тавигдсанаас халаалт муу, эмчийн байрны паарнаас байнга ус гоождог, муу усны шугам хөлдөж битүүрсэн, бохир ус соролт муу, эмийн сангийн зориулалтаар баригдсан өрөө нь зураглалын дагуу баригдаагүй жижиг байна.

Нийслэлд:

- "Морин сувд" ХХК-ийн гүйцэтгэсэн 2,928.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй Цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих, 240 ор /УБ, Хан-Уул дүүрэг, 28 дугаар цэцэрлэг/ ТАХ-ний зураг төсөлд биеийн тамир, хөгжмийн танхимыг БНБД-II-66-6825-д заасны дагуу байгалийн гэрэлтүүлэг тусахаар саруулхан том цонхтой, агаар солилцох салхивчтай байхаар тусгасан байхад цонх нь жижиг гэрэлтүүлэг болон агаар сэлгэлт муу өрөө тасалгаанд сургалт хүмүүжлийн ажил явуулж байна;
- "Морин сувд" ХХК-ийн гүйцэтгэсэн 1,800.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Хан -Уул дүүрэг, 189 дүгээр цэцэрлэг/ ТАХ-ний гадна цэвэр усны шугамын халаалтын кабель ажиллагаагүй тасарсан, бохир усны гаргалгаа худагт дулаалгатай таг хийгдээгүй, ангиудын угаагуур, суултуур эвдэрсэн, холигч уян холбоос муудсан, гал тогооны утаа сорогчийн цахилгааны утас холбогдоогүй;
- "ТЭТҮ" ХХК-ийн гүйцэтгэсэн 2,490.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй Цэцэрлэгийн барилга 150 ор худалдан авах /УБ хот, БЗД, 6 дугаар хороо/ ТАХ нь Сургуулийн өмнөх

боловсролын байгууллагын орчны стандарт, МХЕГ-ын даргын 2017 оны “Үлгэрчилсэн дүрэм батлах тухай” А/179 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.426, 2.527, 2.928, 3.629-д тусгагдсан сургалт-хүмүүжлийн барилга байгууламжийг хөдөлгөөн, дуу шуугиан ихтэй гудамж, утаа, тортгийн эх үүсвэрээс 500-аас доошгүй метр газарт барьж байгуулах, өөрийн эдэлбэр газартай байх, эргэн тойронд бут, сөөг тарьж ногоон байгууламж байгуулах ба нийт талбайн 50-аас доошгүй хувийг зүлэгжүүлэн, мод тарьж, 50 хүртэлх хувийг цардаж зассан байх, эдэлбэр газартай байх /хичээллэх биеийн тамир спортын, амрах, аж ахуйн/, сургуулийн өмнөх насны хүүхдийн барилгын давхрын дээд хязгаар 2 давхар байх зэрэг шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал уг барилга нь амины орон сууцны зориулалтай, 3 болон 4 дүгээр давхартаа анги танхим хуваарилсан, стандарт шаардлага хангасан эдэлбэр газаргүй, анги танхим, ариун цэврийн өрөөний талбайн хэмжээ бага, анги танхимууд байнгын нар үздэггүй хойд зүг харсан цонхнуудтай зэрэг цэцэрлэгийн барилгад тавигдах наад захын шаардлагуудыг хангахгүй байна.

Өвөрхангай аймагт:

- Төрийн байгууллагуудын барилгын их засвар төслийн хүрээнд Зүүнбаян-Улаан сумын Эмгэд багийн төвийн их засварын ажлыг “Өв дулаан” ХХК 48.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна. Багийн төвийн барилгын өргөтгөлийн хэсгийн цонхны амлагаа чанаргүй хийгдсэн, барилгыг тойруулсан хаяавч бетон цутгагдаагүй;
- Боловсрол, соёлын салбарын байгууллагуудын их засвар багцын хүрээнд Баянгол сумын дотуур байрны их засварын ажлын дотуур байранд солигдсон ихэнх хаалганы хатаалт муу байснаас үүдэн хавтасны углуурга суларч, ангайсан байдалтай;
- Боловсрол, соёл, спортын салбарын их засвар багцын хүрээнд Бат-Өлзий сумын 100 хүүхдийн дотуур байрны засварын ажилд агааржуулалтын суваг цэвэрлэгдээгүй, парпедны дотор талыг шохойдоогүй, дээвэрт халааж наадаг чулуутай, чулуугүй хар цаасыг чанаргүй наасан, дээврийн хар цаас хойд талаасаа дээврийн дунд хэсэг хүртэл хуйларсныг олсоор даруулсан, гадна фасадын эмульс будах ажлын гүйцэтгэл чанаргүй болсон;
- “Дөлгөөн арвай” ХХК-ийн 21.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн Тарагт сумын цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажилд нийт засах дээврийн талбайгаас 200 орчим м.кв талбайн ажил, засварын ажлын батлагдсан тоо хэмжээнээс хуйлмал дээвэр буулгах, цементэн тэгшилгээ задалж буулгах, шинээр хийх зэрэг ажлууд хийгдээгүй байна. Засвар хийгдсэн хэсгийн дээврийн бикростыг парпедны ирмэг хүртэл наасан боловч чанаргүй гүйцэтгэснээс хуйларч ховхрон ус, чийг нэвчих эрсдэлтэй;
- Арвайхээр сумын 5 дугаар ЕБС-ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Аж констракшн” ХХК ажилласан. Барилгад нэмэлтээр 648.0 сая төгрөгийн гадна талбайн тохижилт, хашааны ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулагдсан бөгөөд сургуулийн хөл бөмбөг, сагсан бөмбөг болон ногоон байгууламж, тохижилтын ажил хийгдээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон;
- Баянгол сумын Өнц багийн төв, Богд сумын Далангийн 5 дугаар багийн төвийн барилгууд бүрэн ашиглалтад орсон боловч халаалтын асуудал бүрэн шийдэгдээгүйгээс хүйтний улиралд ажиллах нөхцөл бүрдээгүй тул байнгын үйл ажиллагаа явуулах боломжгүй;
- Бат-Өлзий сумын ЗДТГ-ын өргөтгөл, их засварын ажил дууссан боловч өргөтгөлийн барилгын хана хэт нимгэн, бэхлэгээ байхгүй, агааржуулалтгүй, галд тэсвэр муутай материал хэрэглэсэн зэрэг шалтгаанаар улсын комисс хүлээн аваагүй байна.
- Сумдын ЕБС-ийн хими, физикийн кабинетыг стандартын дагуу тохижуулаагүйгээс хэрэглэгдэхүүнийг ашиглах боломжгүй байна;
- Богд, Баруунбаян-Улаан, Гучин-ус сумдын ЕБС-дад “Сүүн хүнгий” ХХК-ийн нийлүүлсэн Grand starix маркийн автомашиныг бүртгэлд тусгаагүй, тус 3 автомашин нь ашиглалтын шаардлага хангаагүй, эвдрэл ихтэйгээс ашиглагдахгүй байна;
- Хужирт сумын ЕБС-д “Их тэнгэрийн илд” ХХК-ийн нийлүүлсэн Starix маркийн автомашины хянах самбар нь ажиллахгүй ирсэн, нийлүүлэгч хянах самбарыг засуулахаар авч явсан ч засагдалгүй ирсэн бөгөөд өнөөг хүртэл ашиглагдаагүй байна.

Дархан-Уул аймагт:

- “Хос анар” ХХК-аас Дархан сумын Оюун ирээдүй, Од цогцолбор болон 9 дүгээр сургуульд нийлүүлсэн компьютер, тоног төхөөрөмжөөс 13 нэр төрлийн 7.3 сая

төгрөгийн тоног төхөөрөмжийн үзүүлэлт захиалагчийн техникийн тодорхойлолтоос зөрсөн;

- “Сүвэн-Уул” ХХК-аас Дархан сумын “Түвшин холбоо” өрхийн эрүүл мэндийн төвд нийлүүлсэн суурин даралтын аппаратын асаах үүсгүүр байхгүй, Орхон, Хонгор, Шарын гол сумдын эмнэлгийн мобайл ЭХО-ны ірад байхгүй байна;
- “Өсөх буянт тулга” ХХК-ийн гүйцэтгэсэн Дархан сумын 12 дугаар сургуулийн дотуур байрны засварын ажлын суурилуулсан хаалганы амлагаа муу хийгдэж, гажсан, таазны шохой унасан байна;
- “Дархан Хөлөг” ХХК-ийн гүйцэтгэсэн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн үүдний хэсгийн дээвэр хийгдээгүй, 2 өрөөний цонхны шил хагарсан, вакум цонх, хаалганы түгжээ, нугас гажсан, хяналтын камерын дэлгэц болон хард диск, зарлан мэдээллийг систем байхгүй, барилгын гадна талын цардмал хатуу хучилттай зам хийгдээгүй;
- “Цагаан зуун” ХХК-ийн гүйцэтгэсэн Дархан сумын 7 дугаар багт баригдсан 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын төсөвт тусгагдсан 3.8 сая төгрөгийн зүлэгжүүлэлт, 2.4 сая төгрөгийн зөөлөвчтэй хавтангийн ажил хийгдээгүй, мөн барилгын 1 дүгээр давхрын коридорын паркет хөндийрсөн, хойд талын довжоо гулзайсан, усны хаялга дутуу хийгдсэн;
- “Ноён өндөр констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн Дархан сумын 13 дугаар багт хийгдсэн бохирын шугам, хоолойн их засвар ажлын ус дулаан дамжуулах төвийн 2 барилгын цонхнуудын будаг ховхорсон байна.

Өмнөговь аймагт:

- Манлай сумын төвийн цэвэр, бохир усны шугам, сүлжээ, цэвэрлэх байгууламж барих ажлын ундны усны эх үүсвэрийг зураг төсвийн дагуу холбоогүй.
- Цогтцэций суман дахь 200 хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар худалдан авсан барилга нь анх үйлчилгээний зориулалтаар хийгдсэн тул MNS6558:2015, ISO8124 цуврал стандартыг хангасан гадаа тоглоомын талбай, ногоон байгууламж, гадна зориулалтын автомашины зогсоол байхгүй, цэвэр бохирын шугамд холбогдоогүй, хөдөлгөөнт төв замд ойрхон, захиалагчийн ажлын даалгавар, ерөнхий шаардлагыг хангаагүй;
- Даланзадгад сумын 9 дүгээр цэцэрлэгт зөөлөн эдлэл нийлүүлэх ажлыг гүйцэтгэгч техникийн тодорхойлолтод заасныг баримтлаагүй, дутуу хивс дроз нийлүүлсэн;
- Даланзадгад сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрын барилгын их засварын ажлыг гүйцэтгэгч зураг, төсөв, ажлын тоо хэмжээнд зааснаар 2 дугаар давхрын вестибюл, коридорын ажлыг гүйцэтгээгүй;
- Ханбогд сумын Сургуулийн барилгын их засварын ажлын дээврийн төмөр хуурсан, борооны ус дээврээс нэвтэрсэн, гадна талын пасад хуурч унасан зэрэг нь чанарын шаардлагад нийцэхгүй ажил хийгдсэн;
- Ханбогд сумын сургуулийн дотуур байрын барилгын их засварын ажил дуусаагүй, ариун цэврийн өрөө, агааржуулагч байхгүй, ариун цэврийн өрөө, дүшний өрөөний тусгаалалт хана хийгдээгүй байна.

Говьсүмбэр аймагт:

- “Говьсүмбэр аймгийн Лаборатори 5 дугаар сургууль, Шивээговь сумын 3 дугаар сургуулийн дотуур байранд тавилга тоног төхөөрөмж худалдан авах ажил”-ыг хүлээн авсан гэж акт үйлдсэн боловч техникийн тодорхойлолт, тоо хэмжээнд заасан тоног, төхөөрөмж, эд хогшлыг нийлүүлээгүй;
- “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга”-ын ажлын гүйцэтгэгч “Хан атрибут” ХХК-ийн 2019 оны гүйцэтгэлийн тайланд графикийн дагуу 1 давхрын цутгалт, 2 давхрын дам нуруу, хучилтыг хийсэн гэж гүйцэтгэл гаргасан боловч дээрх ажлууд өнөөг хүртэл хийгдээгүй;
- Соёлын сайдын багцад батлагдсан “Монгол соёл-Монгол хүмүүн” хөтөлбөрийн хүрээнд 48.3 сая төгрөгийн өртөгтэй 25 ширхэг зөөврийн компьютерыг гүйцэтгэгч “Ай Ти зон” ХХК-аас 2020 оны 12 дугаар сарын 21-нд хүлээн авсан боловч захиалагч буюу аймгийн ЗДТГ тодорхойгүй шалтгаанаар ашиглагч байгууллагад хүргүүлээгүй, агуулахад хадгалж байна;
- БШУС-ын багцаас эрх шилжсэн 39.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Говьсүмбэр аймгийн Лаборатори 5 дугаар сургууль, Шивээговь сумын 3 дугаар сургуулийн дотуур байранд тавилга, тоног төхөөрөмж” авах ажлыг бүрэн хүлээн авсан гэж акт үйлдсэн боловч гүйцэтгэгч ажлыг бүрэн хүлээлгэн өгөөгүй байна.

Дорнод аймагт:

- “Бүжнэр” ХХК-ийн 60.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн Дотуур байрын барилгын их засвар /Дорнод, Булган сум/ ТАХ-г байнгын ашиглалтад оруулах комисс 2020 оны 5 дугаар сард үүрэг даалгаврын хэрэгжилтээр хүлээн авч, сургуулийн дотуур байрыг холбосон хүзүүвчний барилгын ажил дууссаны дараа гадна фасадын ажлыг гүйцэтгүүлэхээр заасан боловч өнөөг хүртэл дутуу ажлыг гүйцэтгээгүй;
- 1,417.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Бага сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудал /Дорнод, Хэрлэн сум, 1, 5 дугаар сургууль/ ТАХ нь зураг төсвийн магадлалын дүнгээс 75.2 сая төгрөгөөр дутуу батлагдсан байна. Тус 2 барилга ашиглалтад орсон боловч 5 дугаар сургуулийн 3 давхрын 2 ангийн дээврээс ус гоождог, дотор сантехникийн холбоосууд 3-4 газарт ус алдсан, хойд талын гадна фасадын будаа, 3 давхрын ханын будсан хэсгүүд хуурч унасан байдалтай байна.

Дундговь аймагт:

- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сайнцагаан сум/ ТАХ-ний гүйцэтгэгч “Эйч Ар Ви” ХХК барилгын зарим ажлыг өвлийн улиралд гүйцэтгэсний улмаас хоёр давхрын ихэнх өрөөнүүдийн хананд цууралт үүссэн. Магадлашгүй ажлын зардлаас 1.5 сая төгрөгийн “Ус халаагч” суурилуулсан боловч ашиглаагүй.

Говь-Алтай аймагт:

- БШУС-ын багцаас 3,581.6 сая төгрөгийн өртөгтэй “Урагшлах” ХХК гүйцэтгэсэн Баян-Уул сумын 640 суудалтай ерөнхий боловсролын сургууль 2017 онд ашиглалтад орсон. Дээврээс ус орж ангиудын дохиолол шатаж, цахилгааны монтаж гэмтсэн, спорт заалны дээвэр усны хаялга байхгүй, өнгөлгөөний тоосгоны өнгө ховхорсон;
- БШУС-ын багцаас 5,420.0 сая төгрөгийн өртөгтэй “Жинст Транс” ХХК гүйцэтгэсэн Есөнбулаг сумын 960 суудалтай ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль 2019 онд ашиглалтад орсон. Дээврээс урлагийн заал руу ус алдсан, суулт өгч цонх хагарснаар салхи шороо орох, дулаан алддаг, суулт өгснөөс шалтгаалж бохир дамжуулах шугам хагарч засварласан;
- БШУС-ын багцаас 5,888.2 сая төгрөгийн өртөгтэй “Манхан Уст” ХХК гүйцэтгэсэн Есөнбулаг сумын 960 суудлын Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай дахь салбар сургууль 2020 онд ашиглалтад орсон. Гадна дотор талд хана хөндлөн болон босоо чиглэлээр хагарал үүссэн, цонх хагарсан, дулаан алдалттай, халаалтын дотоод систем алдаатай хийгдсэн, ариун цэврийн өрөөний халаалтын секц байхгүйгээс хөлдсөн, бохирын агаар сэлгэлтийн сэнс мултарч унасан, 10 өрөөний цахилгааны залуур шатсан, 3 давхрын өрөөнүүдэд дээврээс ус ордог, агааржуулалтаас ус гоожиж камерын өрөөний хана хөгцөрсөн, гадна талын хаалга эвдэрсэн, нийтийн бохирын хянахын цонх байхгүй, парпет төмөр салхинд урагдсан;
- БШУС-ын багцаас 1,899.3 сая төгрөгийн өртөгтэй “Цахиур толгойн орд” ХХК гүйцэтгэсэн Дарви сумын 320 суудалтай ерөнхий боловсролын сургууль 2019 онд ашиглалтад орсон. Цайны газрын цонх хагарсан, цонхны хавтангуудын дундуур ус ордог, ногоон байгууламж зурагт тусгагдсанаар хийгдээгүй, интернэтийн доголдол гарч ангиуд холбогддоогүй, гал тогооны уур сорогч шаардлага хангадаггүй, зарим нойл, гар угаалтуур холбогдоогүй, дутуу ажилладаг;
- ЭМС-ын багцаас 1,289.0 сая төгрөгийн өртөгтэй “Арвин бэлт” ХХК гүйцэтгэсэн Дарви сумын эрүүл мэндийн төвийн барилга 2019 онд ашиглалтад орсон. Гадна талбайд чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж суурилуулаагүй байна.

2.54. ТЕЗ-аас орон нутагт эрх шилжүүлээгүй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хангалтгүй тавьснаас төсөл, арга хэмжээ үр ашиггүй болж, орон нутгийн хэрэгцээ, шаардлага хангагдаагүй байна. Тухайлбал,

БХБЯ:

- “Сумын төвийн уурын зуухны шинэчлэл /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгч “Хасу Мегаватт” ХХК батлагдсан зураг төсөлгүйгээр барилгуудын дулааны ачаалалд хүрэлцэхгүй зуухыг суурилуулсан, зуух болон түлж байгаа нүүрс хоорондоо тохирохгүйгээс халаалтын зуух, сүлжээний усны температур хэвийн хэмжээнд хүрэхгүй байгаа нь төсөл, арга хэмжээ ашиглагдах боломжгүйд хүрч, үр ашиггүй болсон байна.

2.55. Төсөл, арга хэмжээний зураг төслийн зардлын санхүүжилтийг барилга, байгууламжийн тендерийн төсөвт туссан зураг төслийн зардал болон зохиогчтой байгуулсан гэрээний дүнгээс зөрүүтэй олгосон байна. Тухайлбал,

Хэнтий аймагт:

- Нийт 4 ТАХ-ний зураг төсөл зохиогчид гэрээний дүнгээс 38.2 сая төгрөгийг илүү шилжүүлсэн, мөн Батноров, Мөрөн, Жаргалтхаан сумдын цэвэр усны шугамын магадлалаар батлагдсан төсөвт тусгаадаагүй зураг төслийн зардлыг шилжүүлсэн.

Өвөрхангай аймагт:

- Сургуулийн барилга, 320 суудал /Өвөрхангай, Арвайхээр/, Бага сургуулийн барилга, 240 суудал /Өвөрхангай, Сант сум/ ТАХ нь жишиг зургаар баригдаж байгаа боловч ГХБХБГ-аас дахин “Креатив монголиа” ХХК, “Аслаан” ХХК-д зургийн даалгавар өгч шинээр зураг, төсөв хийлгэхээр гэрээ байгуулсан байна.

Говьсүмбэр аймагт:

- Өмнөх оноос он дамжин хэрэгжиж буй 5,629.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Сүмбэр сумын 640 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсвийг “Эй Эн И И” ХХК 2013 онд аймгийн ОНХС-гийн 25.0 сая төгрөгийн хөрөнгөөр 960 хүүхдийн багтаамжтай байхаар төлөвлөж ажлыг гүйцэтгээд байсан боловч аймгийн Засаг даргын 2017 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ЗД-07/2017 тоот зураг төслийн ажлын даалгавраар хүүхдийн тоог 640 болгон бууруулж, нэмэлт 10.0 сая төгрөгийн гэрээ байгуулан шинээр зураг төсөл боловсруулж магадлалаар баталгаажуулсан бөгөөд энэ нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй байна

2.56. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширч, үр ашиггүй болж байна. Тухайлбал,

Хэнтий аймагт:

- Улсын төсвийн хөрөнгөөр 2011 оноос хойш хэрэгжиж байгаа 11,459.4 сая төсөвт өртөгтэй Ханхэнтий чуулгын барилгын гүйцэтгэгч “Макс майнд” ХХК-нд захиалагчийн зүгээс ажлыг шуурхайлах шаардлагыг удаа дараа тавьдаг ч ажиллах хүчний болон санхүүгийн чадамжгүй байдал, гэрээ сунгаадаагүй шалтгаанаар ажлаа оройтож гүйцэтгэх, Коронавируст халдварын цар тахлын нөлөөгөөр үүссэн барилгын материалын хомсдол, хол хорио зэргээр гүйцэтгэгч гүйцэтгэл удааширч байгаа гэсэн тайлбар өгснөөр барилга угсралтын ажил зогссон;
- Сургуулийн барилга, 1500 суудал /Хэнтий, Хэрлэн сум/ ажлыг гүйцэтгэх гэрээний биелэлтийг Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 86 дугаар захирамжаар “Захиргааны хэрэг”-ийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд түдгэлзүүлсэн байна.

2.57. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд зураг төсөл зохиогчоор хяналт хийлгэхгүй байгаа нь гүйцэтгэгч төсөл, арга хэмжээг зураг төслийн дагуу бүрэн гүйцэтгэхгүй байх эрсдэлтэй байна. Тухайлбал,

Хэнтий аймагт:

- Эрх шилжсэн нийт ТАХ-ний 47.7 хувь буюу 21 нь зураг төсөл зохиогчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй. Мөн 29.4 сая төгрөгийг зохиогчийн хяналтын гэрээгүйгээр олгожээ.

2.58. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ажлыг гүйцэтгэгч дутуу болон чанаргүй гүйцэтгэснээс ашиглагч байгууллагаас гомдол ирүүлсэн байна. Тухайлбал,

Архангай аймагт:

- “Эсгэл” ХХК-ийн “Мал угаалгын цэг байгуулах” ажлын хүрээнд Өлзийт суманд хийгдсэн ажил нь шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй байгаа талаар ашиглагч Сумын Засаг даргаас гомдол ирүүлсэн. Ажлыг дутуу чанаргүй гүйцэтгэсэн байхад улсын комисс ашиглалтад хүлээн авсан;
- “Цагаан сүмбэр” ХХК-ийн гүйцэтгэсэн Хангай сумын дотуур байрны өргөтгөлийн барилгыг улсын комисст хүлээлгэн өгсөн боловч ашиглагчийн зүгээс ажлыг дутуу гүйцэтгэсэн, уурын зуухны сөрөлт муу байгаа талаар гомдлыг ирүүлсэн;

- *“Хатуу төмөр” ХХК-ийн гүйцэтгэсэн Хашаат сумын Соёлын төвийн барилгын дээрээс дусаал гоождог, паркетан шал норж ховхорсон тухай гомдлыг ашиглагчаас ирүүлсэн байна.*

2.59. ТЕЗ-ийн хариуцлагагүй байдлаас Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр худалдан авах ажиллагаа зарлагдаж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдан ажил нь эхэлсэн төсөл, арга хэмжээг хасуулсан нь төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашгийг бууруулж байна. Тухайлбал,

ЭМЯ:

- *Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын сум дундын эмнэлэгт их засвар хийх 88.7 сая төгрөгийн гэрээг Баян-Өлгий аймгийн Засаг дарга “Мунара констракшн” ХХК-ын хооронд 2020 оны 7 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан бол тус компани мөн оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн байдлаар засварын ажлын нийт гүйцэтгэлийг гаргаж баталгаажуулснаар улсын комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан боловч улсын төсвөөс тодотголоор санхүүжилт хасагдсан, 2021 онд төсвийн тухай хуульд тусгаадаагүй байна.*

2.60. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд батлагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал,

ЭМЯ:

- *ХӨСҮТ-ийн био устгалын 3 дугаар шатлалын лабораторийн барилгын дуусгал ажлын 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр тендер зарлаж, уг лабораторид тавилга, ширээ сандал худалдаж авсан байна.*

2.61. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахын тулд Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөх зайлшгүй шаардлагатай байна. Мөн Төсвийн ерөнхийлөн захирагч нар шинээр батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжит хугацааг харгалзан зохион байгуулж, үе шатанд зохиогчийн болон захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа эрх зүйн зохицуулалтыг чанд мөрдөх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах бүлэг дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн талаар:

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуульд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөс 7 төсвийн ерөнхийлөн захирагчийн 90.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 10 төсөл, хөтөлбөрийг орхигдуулж, уг хөтөлбөрт батлагдаагүй техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээг баталсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоонд байгууллагуудын уялдаа холбоо сул байгааг харуулж байна.
2. УИХ-ын 2019 оны 54 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д улсын төсвийн хөрөнгө оруулалт болон холимог эх үүсвэр (гадаад эх үүсвэр, улсын төсөв)-ээс эдийн засгийн ангиллаар 29 зорилт, арга хэмжээг 1,313.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгаснаас Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд 433.6 тэрбум төгрөгөөр санхүүжих дүнтэй 8 зорилт, арга хэмжээг батлаагүй нь хөгжлийн бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
3. Төсвийн ерөнхийлөн захирагч нар салбарын түвшинд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгцээ, шаардлага, үр ашгаар нь эрэмбэлээгүйгээс Засгийн газраас баталсан 2020 оны хөрөнгийн зардлын төсвийн хязгаараас 4.4 дахин давсан дүнтэй хөрөнгө оруулалтын төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлсэн нь салбарын нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох үйл ажиллагаа дутуу хийгдэж байгааг харуулж байна.
4. Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн саналд тусаагүй, хэрэгцээ, шаардлагын үндэслэл тооцоолол бүрэн бус 185 барилга, байгууламжийг Засгийн газар, УИХ-ын хэлэлцүүлгийн үе шатанд нэмж хуульд шинээр баталсан нь салбарын бодлого алдагдах сөрөг нөлөөтэй байна.
5. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй 39.6 хувь буюу 334 төсөл, арга хэмжээг тусгаснаас эдгээр төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх, үр ашиг буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй болох нөхцөлийг бүрдүүлсээр байна.
6. Нормативт хэмжээгээр ерөнхий боловсролын сургуулийн барилгын хэрэгцээ, шаардлагагүй 9 суманд сургуулийн барилгыг төлөвлөсөн нь барилгын ашиглалтгүй талбайг бий болгож төсвийн хөрөнгийг байрны халаалт, урсгал зардалд үр ашиггүй зарцуулахаар байна.
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хүн амын тоотой бүрэн уялдуулж төлөвлөөгүйгээс нийгмийн тогтвортой хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.
8. Төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаанд уялдуулж санхүүжилтийг төлөвлөөгүй, төрийн өмчид бүртгэгдэхгүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг зөрчил хэвээр байна.
9. Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn цахим хуудсыг ашиглалтад оруулсан боловч Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт уг системийн шаардлага, аргачлалын дагуу хийгдээгүйгээс төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдах зөрчил давтагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах талаар:

10. Төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын нийт худалдан авах ажиллагааны 17.8 хувийг 2020 оны сүүлийн хагас жилд зохион байгуулсан нь төсөл, арга хэмжээ тайлант онд бүрэн хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
11. Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад ТБОНӨХБАҮХАТХ болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийн зохицуулалт зөрчигдсөөр байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаар:

12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 10800 суудалтай 30 сургууль, 8515 ортой 64 цэцэрлэг, 2145 ортой 22 дотуур байр, 645 ортой 22 эмнэлэг, 155.9 км автозам, 659.6 у/м гүүрийн байгууламж, 326.1 км ЦДАШ, 4240 суудалтай 17 соёлын төв тус тус ашиглалтад орсон байгааг өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад эрчим хүчнээс бусад салбарын барилга, байгууламжийн хүчин чадал өссөн үзүүлэлттэй байна.
13. Тайлант оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дүнг салбараар нь авч үзвэл, нийгмийн салбарт 47.5 хувь буюу 631.3 тэрбум, дэд бүтцийн салбарт 31.6 хувь буюу 420.8 тэрбум, бусад салбарт 20.9 хувь буюу 278.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр хуваарилсан байна.
14. Сангийн яам улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 78.4 хувь буюу 1,043.2 тэрбум төгрөгийг бодит ажлын гүйцэтгэлээр, Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолын дагуу 3.8 хувь буюу 50.4 тэрбум төгрөгийг 10 Төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах замаар олгосон байна.
15. Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2020 оны зарцуулагдаагүй хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдэл 237.3 тэрбум төгрөгийг төсөвт татан төвлөрүүлснээс 86.9 хувь нь ажлын гүйцэтгэл гараагүй болон гэрээ байгуулаагүйгээс шалтгаалсан нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсан байна.
16. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар батлагдсан зарим төсөл, арга хэмжээний үе шатны ажлын санхүүжилтийг Засгийн газрын тогтоолоор захиалагч байгууллагын барьцаа хөрөнгийн дансанд он дамжуулан байршуулахаар шийдвэрлэсэн нь данс, бүртгэлийн тогтолцоо алдагдах эрсдэлийг үүсгэж байна.
17. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд зохиогчийн болон захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс зарим барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүйд хүрсэн байна.
18. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байнгын ашиглалтад хүлээн авсан 10 аймгийн нийт 97.7 тэрбум төгрөгийн өртөгтэй төсөл, арга хэмжээг улсын болон орон нутгийн өмчид бүртгээгүй, санхүүгийн тайланд тусаагүй байгаа нь нийтийн өмч эзэнгүйдэх эрсдэлтэй байна.
19. Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээр нийт 353.7 тэрбум төгрөгийн 385 зөрчил илэрсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилт болон хяналт, хариуцлагын тогтолцоо сул байгааг харуулж байна.
20. Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 11.2 хувь буюу 151 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 15.2 хувь буюу 205 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дутуу байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна.
21. Төсвийн ерөнхийлөн захирагч нар тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжиж байнгын ашиглалтад орсон төсөл, арга хэмжээний үр нөлөөг тооцохгүй байгаагаас тухайн жилийн салбарын бодлогын зорилтод хүрэх түвшин биелсэн эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд толилуулах нь:

1. Улсын төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй нийцүүлэн баталж, салбарын түвшинд төлөвлөөгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хуульд тусгаж буй зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэлээр хариуцлагын болон үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрэн бүрдүүлэх;
2. Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс, дотоод аудитын албаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар сүүлийн 10 жилд Улсын Их Хуралд толилуулсан асуудалд шинжилгээ хийлгэж, үр дүнг Төсвийн байнгын хороонд танилцуулах чиглэлээр үүрэг өгч ажиллахыг тус тус толилуулж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Төсвийн ерөнхийлөн захирагч нарын үйл ажиллагаанд сайн засаглалын тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээг авч, төсвийн төлөвлөлтөд улсын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төсөв хоорондын уялдааг хангуулах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийн төслийг боловсруулахад ил тод, хариуцлагатай байх зарчмыг мөрдөж, салбараас хүргүүлсэн төсвийн саналд тусгагдаагүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд нэгтгэхгүй байхад анхаарч, хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах;
- Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийг зөрчсөн төрийн албан хаагчдад уг хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага тооцох;
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн байнгын ашиглалтад хүлээн авсан нэр бүхий 10 аймгийн нутаг дэвсгэрт байрших нийт 97.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг улсын болон орон нутгийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулж, нийтийн өмчийг эзэнжүүлэх.

Сангийн сайдад:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн жил дамжуулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах, банкны баталгааг үндэслэн олгох зохицуулалтыг хууль, эрх зүйн баримт бичигт тусгах, төсвийн сахилга батыг хангуулах;
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар батлагдсан зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон гэрээний дүнгээс магадлалаар баталгаажсан төсвийн дүн бага байгаа талаарх /аудитын тайлангийн хавсралт 3-т дурдсан/ зөрчлийг арилгах арга хэмжээ авч, эдгээр төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эрхийг нээхдээ магадлалаар баталгаажсан төсөвтэй тулган баталгаажуулах;
- Монгол Улсын 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үр ашгийг дээшлүүлэх, төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг батлуулах үүднээс төсвийн төлөвлөлтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын

системийн шаардлага, аргачлалын дагуу зохион байгуулах, цахим сангийн ашиглалт, хэрэглээг төлөвшүүлэх.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хэрэгжих төсөл, арга хэмжээг хэрэгцээ, шаардлага, үр ашгаар нь эрэмбэлэн төсвийн хязгаарт багтсан төсвийн саналыг хүргүүлж, төсвийн төлөвлөлтөд хууль, эрх зүйн орчныг чанд мөрдөж ажиллах;
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу төсөвт өртгийг тойм дүнгээр баталж хэрэгжүүлсэн, газрын асуудал шийдэгдээгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсвийг батлуулаагүй, ажил гүйцэтгэх гэрээний дүнгээс магадлалаар баталгаажсан төсвийн дүн бага байгаа зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт болон захиалагчийн хяналтыг чангатгаж, холбогдох зохицуулалтыг хийх;
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд зохиогчийн болон захиалагчийн хяналт үр дүнтэй хэрэгжээгүйгээс барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүйд хүрч байгаад анхаарч, хяналт хэрэгжүүлэгч байгууллагатай үр дүнг тооцож ажиллах;
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж байнгын ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний үр нөлөөг тооцож, тухайн жилийн бодлогын зорилтот түвшинд хүрсэн эсэх талаар дүгнэлт гаргадаг байх.

Холбогдох байгууллагын санал



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР З.ЗАНДАНБАТ ТАНАА**

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД


15160 Улаанбаатар хот, Чингэлтай дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Зөсгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2021.06.08 № 9/3134
Танай 2021.06.08 -ны № 1537 -т

**Тайлангийн төсөлд санал
өгөх тухай**

Танаас ирүүлсэн 2021 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 1537 тоот "Тайлангийн төсөлд санал авах тухай" албан бичигтэй танилцлаа.

Үндэсний аудитын газраас Монгол Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж тусгах санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.



Б.ЖАВХЛАН

9761004867

Сангийн сайдын 2021 оны 6 сарын 08-
ний өдрийн 9334 албан бичгийн хавсралт

ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ТУСГАХ САНАЛ, ТАЙЛБАР

1. Тайлангийн төслийн 2.42-2.46 хэсэгт тусгагдсан зөрчил нь зураг төсөв зохиогч, захиалагч, захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэгч, ашиглагч болон гүйцэтгэгч байгууллагуудын үйл ажиллагаанаас хамаарсан байх тул холбогдох байгууллагуудад энэ талаар тодорхой арга хэмжээ авахыг зөвлөмж тусгах;

2. Сангийн яамнаас сүүлийн 2 жилийн хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор цахим систем болон төслүүдийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлалыг нэвтрүүлэн ажиллаж байгаа хэдий ч төслүүдийн зураг төсөв боловсруулах, зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааны хяналт, хариуцлага сул байгаагаас хамааран төслүүдийн төсөвт өртөг нэмэгдэх, буруу төсөвлөгдөх, төслүүд удаашрах эрсдэлтэй байх тул энэ талаар холбогдох байгууллагуудад тодорхой арга хэмжээ авахыг зөвлөмж хэсэгт оруулах;

3. Тайлангийн төслийн 2.50 хэсэгт дурдсан захиалагч байгууллагууд магадлашгүй ажлын зардал, техник хяналтын зардлыг зориулалт бусаар ашигласан гэсэн байх тул энэ талаар холбогдох байгууллагуудад хариуцлага, хяналтын тодорхой арга хэмжээ авахыг зөвлөмж хэсэгт оруулах;

4. Тайлангийн төслийн "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаар" гэсэн хэсгийн 19-д хууль тогтоомжийн хэрэгжилт болон хяналт, хариуцлагын тогтолцоо сул гэж нэмэх;

---oOo---

Саналд өгөх тайлбар

Сангийн яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг Үндэсний аудитын газраас өгч байна. Үүнд:

Саналын 1 дэх хэсгийг хүлээн авч зөвлөмжид тусгав.

Саналын 2 дахь хэсгийг хүлээн авч зөвлөмжид тусгав.

Саналын 3 дахь хэсэгт дурдсан асуудлаар акт, албан шаардлага өгөгдсөн тул тайланд тусгав.

Саналын 4 дэх хэсгийг хүлээн авч дүгнэлтийн 19 дүгээр хэсэгт тусгав.

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (АГГ-2021/06-ШТА-ГА)

Хавсралт 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн дуусаагүй орхигдсон барилгуудын судалгаа

/сая төгрөг/					
Д/д	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг
1	БХБС	Аймаг, сум, суурингийн нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил /Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл/	2018	2020	1,901.2
2	БХБС	Сумын хэрэглэгчдийг 2-р хэлхээний шугам шинээр татах, Ф219х6мм, ф159х4.5мм, ф133х4.0 мм, ф76х3.5мм-ийг голчтой нийт 996.0/ м урт дулааны шугам /Дорноговь, Замын-Үүд/-ын зураг төслийн үлдэгдэл санхүүжилт	2018	2020	75.0
3	БХБС	Сумын төвийн шинэчлэл /Говь-Алтай, Дэлгэр/	2014	2016	5,000.0
4	БХБС	Халуун ус, ахуй үйлчилгээний барилга / Дундговь, Цагаандэлгэр сум/	2018	2019	237.3
5	БШУС	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Говь-Алтай, Халиун сум/	2018	2019	1,166.3
6	БШУС	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дорнод, Гурванзагал сум/	2019	2019	1,500.0
7	БШУС	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Архангай, Хангай сум/	2018	2018	532.0
8	БШУС	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Мандал сум/	2014	2018	771.2
9	БШУС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/	2014	2020	1,627.9
10	БШУС	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/	2018	2019	2,160.0
11	БШУС	Дотуур байрны барилга 150 ор Дорнод, Цагаан-Овоо сум	2019	2020	1,377.8
12	БШУС	Спорт заалын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг баг/	2018	2018	798.0
13	БШУС	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Баяндэлгэр сум	2019	2020	1,980.0
14	БШУС	Цэцэрлэгийн барилга 100 ор/ Сэлэнгэ, Мандал сум/	2012	2016	762.9
15	БШУС	Дотуур байрын барилга 150 ортой /Баян-Өлгий, Цэнгэл сум/	2019	2020	1,441.0
16	БШУС	Сургуулийн спорт заалын барилга /Дундговь, Адаацаг сум/	2020	2020	933.0
17	ЗГХЭГ	Засаг даргын Тамгын газрын барилга /Завхан, Их-Уул сум/	2013	2013	970.0
18	ЗТХС	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзавр хүртлэх 20.9 км авто зам барих төслийн монголтын талын хөрөнгө /Улаанбаатар/	2018	2020	4,843.6
19	ЗТХС, ИНҮТ	Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилга, гадна цахилгаан, гадна холбооны ажил	2011	2012	1,004.9
20	МУЕС	Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Спорт цогцолборын барилга	2010	2020	1,602.6
21	МУЕС	Дорнод аймгийн Хэрлэн сумын Спорт цогцолборын өргөтгөлийн барилга	2011	2020	2,040.3
22	МУЕС	Соёлын төвийн барилга, 250 суудал /Баянхонгор, Бууцагаан/	2010	2020	1,900.0
23	СС	Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3 /Говь-Алтай, Есөнбулаг/	2015	2015	176.0
24	СС	Үйлчилгээний төвийн барилга /Сэлэнгэ, Ерөө сум/	2012	2016	250.0
25	ХНХС	Ахмад, залуучуудын хөгжлийн төвийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/	2019	2020	2,300.0
26	ХНХС	Залуучуудын хөгжлийн төвийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2019	2020	2,500.0
27	ЭМЯ	Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейн /Дорнод/	2011	2015	1,770.3
28	ЭХС	Төв аймгийн шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах /Төв/	2014	2017	3,881.4
29	ЭХС	Амгалан дулааны станц 348 МВт-ын туршилт, тохируулгын ажил /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2015	2017	3,988.3

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (АГГ-2021/06-ШТА-ГА)

Хавсралт 1-ийн үргэлжлэл

Д/д	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг
30	ЭХС	Ирээдүй цогцолбор хорооллын дулааны 4100 метр гол шугам, 6 ширхэг дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2017	9,267.0
31	ЭХС	220 кВ-ын Улаанбаатар дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станц хүртэлх 110 кВ-ын 9.7 км 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил	2014	2017	938.4
32	ЭХС	110 кВ-ын Баянгол дэд станцаас 110 кВ-ын Радио телевиз дэд станц хүртэлх 24 км 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зурэг, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2017	814.9
33	ЭХС	Баянлиг-Шинэжинст сумын 35 кВ-ын 135 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, шугамын ажлыг эхлүүлэх /Баянхонгор/	2015		4,280.2

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (АГГ-2021/06-ШТА-ГА)

Хавсралт 2. Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд хэрэгжилт нь батлагдсан төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

										/сая төгрөг/			
Д/д	Хуулийн дугаар	ТӨЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	хугацаа		Төсвийн тухай хуульд тусгагдсан төсөвт өртөг		Төсөвт өртөгийн зөрүү	Төсөвт өртөг нэмэгдсэн шалтгаан				
				Эхлэх	Дуусах	2020	2019		Нэмэлт ажил гарсан	Хуульд батлуулсан зурга төсөвгүй туссан	Төсвийн үнэлгээ нэмэгдсэн	Хуульд иж бүрэг зурга төсөвгүй туссан	Бусад
1	Х.1.24	БХБС	Нийслэл, аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /Улсын хэмжээнд/	2018	2020	35,000.0	23,468.3	11,531.7					1
2	Х.2.6	БХБС	Сумын төвийн тохижилт /Увс, Баруунтуруун, Давст, Зүүнговь, Сагил, Тэс, Улаангом, Цагаанхайрхан сум/	2019	2020	9,000.0	6,000.0	3,000.0					1
3	Х.1.27	БХБС	Нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын дулааны шугам сүлжээ, дэд станц /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 11, 15 дугаар хороо/	2018	2021	6,453.8	3,600.0	2,853.8					1
4	Х.1.30	БХБС	Сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ /цэвэр, бохир ус болон дулаан, дулааны эх үүсвэр/ /Ховд, Булган сум/	2019	2021	7,829.9	6,200.0	1,629.9		1			
5	Х.2.3	БХБС	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	2018	2020	3,500.0	3,000.0	500.0					1
6	Х.1.1.1.77	БШУС	Сургуулийн барилга, 920 суудал /Төв, Батсүмбэр сум/	2019	2021	8,987.5	4,907.8	4,079.7					1
7	Х.1.1.1.39	БШУС	Сургуулийн барилга, 1200 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номундалай сургууль/	2019	2020	9,126.2	6,500.0	2,626.2					1
8	Х.1.1.1.37	БШУС	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 1500 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21 дүгээр сургууль/	2018	2020	11,987.2	10,700.0	1,287.2	1				
9	Х.1.1.1.34	БШУС	Спортын төрөлжсөн сургуулийн барилга, 640 суудал /Төв, Зуунмод сум/	2019	2021	5,002.6	3,978.4	1,024.2	1				
10	Х.1.1.1.49	БШУС	Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/	2019	2021	4,383.0	3,432.9	950.1	1				
11	Х.1.1.1.42	БШУС	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Баянбулаг сум/	2019	2021	1,842.0	1,140.0	702.0	1				
12	Х.1.1.1.66	БШУС	Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/	2019	2021	5,629.4	5,000.0	629.4	1				
13	Х.1.1.1.11 8	БШУС	Сургуулийн спорт заалын барилга /Ховд, Булган сум, 1 дүгээр сургууль/	2019	2021	1,500.0	1,100.0	400.0	1				
14	Х.1.1.1.10 6	БШУС	Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь-Алтай, Жаргалан сум/	2019	2020	1,000.0	900.0	100.0	1				
15	Х.1.1.1.10 7	БШУС	Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь-Алтай, Төгрөг сум/	2019	2020	1,000.0	900.0	100.0	1				
16	Х.1.1.1.19	ЗТХС	Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/	2019	2021	41,600.0	12,000.0	29,600.0				1	
17	VIII.1.3.2	CaC	Гаалийн шинэчлэл - Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт, шалгалтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2019	2021	114,143.9	32,195.2	81,948.7					1
18	VIII.1.3.1	CaC	Гаалийн шинэчлэл - Гаалийн ерөнхий газар, газар, хороодын лабораторийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2019	2021	38,310.0	17,000.0	21,310.0					1
19	XIII.1.1.49	CoC	Үндэсний номын сангийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2012	2020	18,900.0	12,000.0	6,900.0			1		
20	XIII.1.1.27	CoC	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Галуут сум/	2019	2020	1,970.0	1,230.0	740.0				1	
21	XIII.1.1.32	CoC	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	2019	2020	1,830.0	1,230.0	600.0	1				
22	XIII.1.1.29	CoC	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Заг сум/	2019	2020	1,767.7	1,230.0	537.7	1				
23	XIII.1.1.45	CoC	Соёлын төвийн барилга, 280 суудал /Өмнөговь, Баяндалай сум/	2019	2021	2,320.7	1,800.0	520.7					1
24	Х.2.1.2	ХНХС	Хөгжил политехник коллежийн барилга /Ховд, Жаргалант сум/	2018	2021	5,277.3	4,383.3	894.0	1				
25	XV/III.1.7	ЭМС	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	2019	2021	17,364.9	8,752.9	8,612.0		1			
26	XV/III.1.5	ЭМС	Нийслэлийн ахмадын эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвийн 3 дугаар амбулаторийн өргөтгөл, 150-200 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2019	2020	8,600.0	5,800.0	2,800.0		1			
Нийт						364,326.1	178,448.8	185,877.3	11	3	1	2	9

Хавсралт 3. Магадлалаар баталгаажсан төсөвт өртгөөс гэрээний дүн давсан төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөг/

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	Гэрээний дүн	Магадлалаар баталгаажсан	Зөрүү
			Эхлэх	Дуусах				
А			1	2	3	4	5	6=5-4
Барилга, хот байгуулалтын сайд								
1	XI.1.120	Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2020	2020	300.00	295.38	74.77	220.61
2	XI.1.85	Сумын төвийн гадна цэвэр усны шугам сүлжээ /Хэнтий, Жаргалтхаан сум/	2020	2020	242.00	240.66	211.43	29.23
3	XI.1.125	Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо/	2020	2020	100.00	93.20	77.67	15.53
4	XI.1.82	Сумын төвийн гадна цэвэр усны шугам /Хэнтий, Баянхутаг сум/	2020	2020	133.50	132.38	127.62	4.76
Боловсрол, шинжлэх ухааны сайд								
5	XII.1.1.188	Дотуур байрын барилга /Дорнод, Хэрлэн сум, Хан-Уул цогцолбор сургууль/ 150 ор	2020	2021	1,783.00	1,750.00	1,718.65	31.35
Зам тээвэр хөгжлийн сайд								
6	XIV.2.1.11	Орхон голын Онгоцтойн амны төмөр бетон гүүрийн үргэлжлэл, 1.3 км зам, 30.68 у/м төмөр бетон гүүр /Өвөрхангай, Бат-Өлзий сум/	2020	2020	1,269.00	1,259.50	771.90	487.61
7	XIV.1.1.152	Дүүргийн соёлын төв дагуух хатуу хучилттай авто зам, 1.6 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/	2020	2021	1,800.00	1,778.37	1,602.85	175.53
8	XIV.1.1.162	Толгойтын замаас Хүнсчдийн гудамжтай холбох хатуу хучилттай авто зам, 0.8 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо/	2020	2021	1,200.00	1,198.77	1,142.48	56.29
Нийт дүн					6,827.5	6,748.3	5,727.4	1,020.9

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (АГГ-2021/06-ШТА-ГА)

Хавсралт 4. Монгол Улсын 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөг/

Д/д	Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Монгол Улсын 2020 оны төсвийн гуйай хууль		Захиалагчийн үйл ажиллагаанаас										Гүйцэтгэлийн үйл ажиллагаанаас	
				Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Зургийн даалгавар алдаатай, зургийн төсөл боловсруулахад хуушаах үзсэн	Шардалангүй төсөл, арга хэмжээний хөрөнгө төлөвлөгөөнд оруулсан	Хөгжлийн өртөг өөрчлөгдсөн	Хөгжлийн өртөг өөрчлөгдсөн	Хөгжлийн өртөг өөрчлөгдсөн	Хөгжлийн өртөг өөрчлөгдсөн	Хөгжлийн өртөг өөрчлөгдсөн	Хөгжлийн өртөг өөрчлөгдсөн	Хөгжлийн өртөг өөрчлөгдсөн	Хөгжлийн өртөг өөрчлөгдсөн	Хөгжлийн өртөг өөрчлөгдсөн	Хөгжлийн өртөг өөрчлөгдсөн
1	II.1.1.8	МУЕС	Спорт заалын барилга /Дундговь, Говь-Утгаал сум/	2019	2020	1,000.0	500.0											1	
2	II.1.1.20	МУЕС	Спорт заалын барилгын үлдэгдэл /Говь-Алтай, Тонхил сум/	2020	2020	200.0	200.0												
3	II.1.1.21	МУЕС	Спорт заал худалдан авах /Ховд, Буянт сум/	2020	2021	200.0	50.0												
4	II.1.1.22	МУЕС	Спорт заалын барилга /Баянхонгор, Шинэжинт сум/	2020	2021	550.0	50.0											1	
5	II.1.1.30	МУЕС	Үндсний төв цэнгэлдэх хүрээлэн /Улаанбаатар/	2020	2021	80,000.0	500.0						1						
6	II.1.3.3	МУЕС	Усан бассейны барилгын тоног төхөөрөмж /Говь-Алтай, Бонбулаг сум/	2020	2020	90.0	90.0							1					
7	IV.1.1.24	ЗГХЭГД	Багийн төвийн барилга /Ховд, Буянт сум, Наранхайрхан баг/	2020	2021	250.0	150.0						1						
8	IV.4.1.3	ЗГХЭГД	Үүрэн хөлбооны сүлжээний өргөтгөл, 4G /Говь-Алтай, Бугат сум, Тазийн тал баг/	2020	2020	40.0	40.0				1								
9	IV.4.1.4	ЗГХЭГД	Үүрэн хөлбооны шинэ сүлжээ тавих /Говь-Алтай, Алтай сум, Урт баг/	2020	2020	200.0	200.0				1								
10	V.1.5	БОАЖС	Тэрийн цагаан нуурын экосистемийг хамгаалах далай /Архангай, Тариат сум/	2019	2020	500.0	100.0				1								
11	V.1.6	БОАЖС	Улс төлийн урсгийг нэмэгдүүлэх "Онон-Уул" төсөл /Дорнод, Хэрлэн сум/	2019	2021	2,500.0	800.0											1	
12	V.2.1	БОАЖС	Монгол Улсын "Төв цэг"-ийн засвар, тохижилт /Өвөрхангай, Бүрд сум/	2020	2020	200.0	200.0							1					
13	VI.3.1	БХС	Эзэсгт хүчний албан хэрэгсэлд нисдэг гэрэг худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2019	2020	4,687.1	991.1									1			
14	X.1.1.4	ХНХС	Сүхбаатар дүүргийн хүүхэд, залуучуудын ногоон бүсийн зуслан /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2020	2021	3,000.0	300.0						1						
15	X.1.1.5	ХНХС	Хүүхдийн "Жаргалант" зуслангийн захиргаа, аж ахуй, гал тогооны барилга /Булган/	2020	2021	925.0	260.0									1			
16	X.1.3.1	ХНХС	Гэр бүл, хүүхэд, ахмадын соёл, амралтын нэгдсэн төлөвлөгөө, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 11 дүгээр хороо/	2020	2021	100.0	50.0							1					
17	X.4.1.16	ХНХС	Сүхбаатар дүүргийн хаягийн бүртгэлтэй ахмадын сувиллын барилга /Хэнтий, Баян-Овоо сум/	2020	2021	1,300.0	50.0							1					
18	X.4.4.1	ХНХС	Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрамж, халамжийн төвийн зураг, төсөв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2020	2021	350.0	50.0							1					
19	XI.1.7	БХБС	Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2013	2020	5,000.0	500.0											1	
20	XI.1.22	БХБС	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/	2019	2020	1,800.0	800.0											1	
21	XI.1.57	БХБС	Багийн явган хүний зам, тохижилт /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант, Цагаанчулуут, Наран, Даваат, Булаг, Баянбулаг, Уртбулаг, Бүрэнбүст баг/	2020	2021	2,000.0	500.0											1	
22	XI.1.61	БХБС	Гүний худал /Увс, Наранбулаг сум/	2020	2020	50.0	50.0							1					
23	XI.1.68	БХБС	Жилин гудамж төсөл-2 /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 14 дүгээр хороо/	2020	2021	3,300.0	50.0							1					
24	XI.1.74	БХБС	Нийтийн бие засах байр /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2020	2020	50.0	50.0							1					
25	XI.1.75	БХБС	Нийтийн эзэмшлийн байруудын гэрэлдүүлэг /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2020	2021	80.0	40.0											1	
26	XI.1.77	БХБС	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороо/	2020	2021	1,640.0	50.0		1										
27	XI.1.92	БХБС	Тосгон чиглэлийн гадна дулааны шугам /Дархан-Уул, Дархан сум/	2020	2021	1,100.0	500.0											1	
28	XI.1.101	БХБС	Удны цэвэр усны шугам, 2.5 км /Хөвсгөл, Цагаан-Уул сум/	2020	2021	1,000.0	50.0							1					
29	XI.1.107	БХБС	Хаймастын авто замын ус зайлуулах хоолой /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо/	2020	2021	800.0	100.0											1	
30	XI.1.108	БХБС	Халуун усны барилга /Баян-Өлгий, Бугат сум/	2020	2020	200.0	200.0							1					
31	XI.1.109	БХБС	Халуун усны барилга /Баян-Өлгий, Сагсай сум/	2020	2021	295.1	50.0							1					
32	XI.1.110	БХБС	Халуун усны барилга /Сэлэнгэ, Шивмар сум, Дулаанхаан тосгон/	2020	2021	450.0	100.0							1					
33	XI.2.10	БХБС	Гадна талбайн тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 14 дүгээр хороо/	2020	2021	600.0	50.0		1										
34	XI.2.15	БХБС	Нийтийн эзэмшлийн байруудын инженерийн шугам сүлжээний засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Орхон баг, 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13 дугаар баг/	2020	2021	430.0	80.0											1	
35	XI.2.30	БХБС	Нийтийн эзэмшлийн орон сууцны орцын их засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18, 19, 27, 29, 38 дугаар хороо/	2020	2021	800.0	50.0											1	

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (АГГ-2021/06-ШТА-ГА)

Хавсралт 4-ийн үргэлжлэл

Д/д	Хуулийн дугаар	ТЭЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль		Захиалагчийн үйл ажиллагаанаас										Гүйцэтгэлийн үйл ажиллагаанаас			
				Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Эзрийн даалгавар алдаатай, урлаг төсөл боловсруулахад хугацаа	Шардлагагүй төсөл, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөсөн, /Эхлэх өргөтгөлд	Хот бус өртөгт хэрэгжүүлэхээр /рөлвөсөн	Газрын асуудал хуушагдаа шийдэгдээгүй, байршил /рчлогдсон	Эрх шилжүүлэх, тендер шагартууллагад хугацаа алдсан, тендер хүчингүй болсон, гэрээ /рж байгуулагдсан	Урлаг, төсөвт дахин магадлал хийсэн, ажлын гүйцэтгэл /ширсэн	Гүйцэтгэл олон жил эгжэж авсан /	Гүйцэтгэлийн багтаамж ирүүлэхгүй /рж байгуулагдгүй	Гүйцэтгэл ажлаа хугацаанд нь /дотгээгүй	Захиалагчийн болон шүүхийн /рууллагад шилжүүлсэн	Барилга урсгалын ажлын явдал /мөхөөгдөн адлиа гаргасан			
36	XI.2.32	БХБС	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/	2020	2021	80.0	50.0														
37	XI.2.34	БХБС	Орон сууцны байруудын дээврийн засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 1, 2, 3, 12 дугаар хороо/	2020	2021	500.0	350.0								1						
38	XI.2.56	БХБС	Хорооны дугуйн зам, тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2020	2021	400.0	50.0	1													
39	XI.2.59	БХБС	Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл, засвар /Говь-Алтай, Бугат сум/	2020	2020	15.0	15.0							1							
40	XI.3.12	БХБС	Хогны ачаа тээврийн автомашин /Говь-Алтай, Бонбулаг сум/	2020	2020	150.0	150.0							1							
41	XI.3.14	БХБС	Хот тохижилтын тусгай зориулалтын дунд оврын автомашин /Говь-Алтай, Бонбулаг сум/	2020	2020	40.0	40.0							1							
42	XII.1.1.8	БШҮС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 240 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо/	2019	2021	2,500.0	800.0													1	
43	XII.1.1.35	БШҮС	Сургуулийн барилга /Баянхонгор, Өлзийт сум/	2019	2020	2,100.0	700.0											1			
44	XII.1.1.57	БШҮС	Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 31 дүгээр хороо/	2018	2021	4,000.0	996.0											1			
45	XII.1.1.58	БШҮС	Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 16 дугаар хороо/	2019	2021	3,700.0	500.0											1			
46	XII.1.1.95	БШҮС	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 71 дүгээр сургууль/	2018	2021	1,500.0	200.0											1			
47	XII.1.1.105	БШҮС	Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь-Алтай, Бигэр сум/	2019	2020	1,200.0	100.0	1													
48	XII.1.1.112	БШҮС	Сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудал /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 4 дүгээр сургууль/	2019	2021	3,100.0	170.0	1													
49	XII.1.1.136	БШҮС	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Налайх дүүрэг, 3 дугаар хороо/	2018	2020	1,100.0	566.1											1			
50	XII.1.1.137	БШҮС	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хөвсгөл, Төмөрбулаг сум/	2019	2020	1,230.0	530.0											1			
51	XII.1.1.141	БШҮС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 4 дүгээр баг/	2019	2020	1,500.0	600.0	1													
52	XII.1.1.151	БШҮС	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Баяндалгэр сум/	2019	2020	2,100.0	1,100.0											1			
53	XII.1.1.160	БШҮС	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Гангар инвест/	2019	2021	2,500.0	100.0						1								
54	XII.1.1.162	БШҮС	Цэцэрлэгийн барилга, 250 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	2019	2021	2,050.0	50.0							1							
55	XII.1.1.163	БШҮС	Цэцэрлэгийн барилга, 250 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 31 дүгээр хороо/	2019	2020	2,500.0	500.0							1							
56	XII.1.1.171	БШҮС	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Оржонтуул сум, Рашаант тосгон/	2018	2020	970.0	100.0	1													
57	XII.1.1.182	БШҮС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо/	2020	2021	3,000.0	300.0							1							
58	XII.1.1.183	БШҮС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 23 дугаар хороо/	2020	2021	3,315.0	300.0							1							
59	XII.1.1.184	БШҮС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо/	2020	2021	2,832.1	300.0							1							
60	XII.1.1.185	БШҮС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 23 дугаар хороо/	2020	2021	3,500.0	300.0							1							
61	XII.1.1.186	БШҮС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо/	2020	2021	3,500.0	300.0							1							
62	XII.1.1.187	БШҮС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 7 дугаар хороо/	2020	2021	3,500.0	300.0						1								
63	XII.1.1.196	БШҮС	Спорт, урлагийн цогцолбор сургууль, 320 суудал /Хөвсгөл, Мөрөн сум/	2020	2021	2,500.0	50.0							1							
64	XII.1.1.201	БШҮС	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Гурванбулаг сум/	2020	2021	1,540.0	50.0							1							
65	XII.1.1.210	БШҮС	Сургуулийн барилга, 320 суудал /Говьсүмбэр, Шивээговь сум, 3 дугаар сургууль/	2020	2021	3,300.0	50.0							1							
66	XII.1.1.211	БШҮС	Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10 дугаар хороо/	2020	2021	3,450.0	50.0	1													
67	XII.1.1.212	БШҮС	Сургуулийн барилга, 320 суудал /Хэнтий, Жаргалтаан сум/	2020	2021	2,473.9	50.0							1							
68	XII.1.1.226	БШҮС	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, 14 дүгээр сургууль/	2020	2021	3,800.0	50.0							1							
69	XII.1.1.227	БШҮС	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, 115 дугаар сургууль/	2020	2021	2,000.0	50.0							1							
